



# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2024 – 04 САР | ДУГААР 65

## ГАРЧИГ



2–3	Бодлогын нийтлэл
4–7	Зохицуулалтын мэдээ
8	Байр суурь
9–10	Тогтвортой санхүүжилт
11–12	Компанийн засаглал, комплайнс
13–14	Финтек ба регтек
15–23	Судлаачийн индэр
24–25	Даатгалын хураамж гэж юу вэ?
26–27	Олон улсын зах зээлийн мэдээ
28	Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ДААТГАЛ

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой үйлчилгээг эрсдэл өндөртэй нөхцөлд үзүүлдэг багийн хамтын ажиллагаа бөгөөд байгууллагын болон хувь хүний эрсдэлт хүчин зүйлээс ихээхэн хамааралтай үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, эмнэлгийн тусламж үзүүлэх явцад эмч, эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын алдааны улмаас өвчтөний бусад эрхтэн системийг гэмтээх, тактикийн алдаа гаргаж онош буруу тавих, буруу эмчлэх, яаралтай үед хариу арга хэмжээг буруу авах зэрэг эрсдэл гарах магадлал их байдаг бол байгууллагын хариуцлагын улмаас зохион байгуулалт оновчгүй байх, стандартыг мөрдөж ажиллаагүйгээс хоёрдогч халдвар тарах, эмийн дасал, гаж нөлөө, шок үүсэх, цацраг туяагаар хордох, хүчилтөрөгчийн дэлбэрэлтэд өртөх зэрэг эрсдэл тохиолдох магадлал өндөр байдаг.

Иймд эрүүл мэндийн салбар дахь эрсдэлийг бууруулах зорилгоор улс орон бүр өөр өөрийн онцлогт тохируулан хариуцлагын даатгалын тогтолцоог бий болгосон байдаг. Олон улсдаа энэхүү даатгалыг Medical Malpractice гэж түгээмэл нэрлэж хэвшсэн байдаг бөгөөд уг даатгал нь эрүүл мэндийн байгууллага болон ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа санамсар болгоомжгүйн улмаас гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх, тэднийг учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилготой. Мөн тус даатгалын бүтээгдэхүүний онцлог нь даатгалын тохиолдлоос гадна өмгөөлөгчийн хөлс, шүүхийн зардал, арбитрын зардал, зөвшилцлийн зардал, шийтгэл болон нөхөн төлбөр, эмнэлгийн хохирол зэрэг зардлуудыг хамруулдаг байна.

Олон улсад уг даатгалыг 2 хэлбэрээр хэрэгжүүлдэг бөгөөд үүнд, Тохиолдол суурьтай (Occurrence Basis) буюу алдаатай эмчилгээ хийснээс хойш хэдэн жилийн дараа ч нэхэмжлэл гаргаж болдог даатгалын гэрээ, эсхүл Нэхэмжлэл Суурьтай (Claims-Made Basis) гэсэн 2 төрлийн даатгалын гэрээг санал болгож байдаг. Тохиолдол суурьтай хувилбар нь уламжлалт даатгалын хэлбэр бол нэхэмжлэл суурьтай даатгалын хувилбар нь даатгалын зах зээлд харьцангуй сүүлд гарч ирсэн ойлголт юм. Нэхэмжлэл суурьтай

даатгалд Ухарч хэлэлцэх хугацаа (Retroactive Date), Тохиолдол нэхэмжлэх хугацааны сунгалт (Extended Reporting Period) гэсэн хугацааны хоёр техникийг ашигладаг.



Үргэлжлэлийг 2-р нүүрт




## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

Албан тушаалынхаа хүрээнд олж авсан аман болон бичгийн нууц мэдээллийг аливаа этгээдэд задруулахгүй байх тухай төрийн албан хаагчдад шаардлага тавигддаг. Хөтөлбөрийн хэрэгжилт, үйлчилгээ зэрэг засгийн газрын ихэнх мэдээлэл нийтэд ил тод байдаг.

Нууц мэдээлэл бол төр засгийн мэдээллийн өчүүхэн хэсгийг эзэлдэг бөгөөд гол төлөв батлан хамгаалах, худалдаа, технологи, улсын тендерийн асуудалтай холбоотой байдаг. Хувь хүний мэдээлэл (жишээ нь иргэдийн орлого, татвар төлсөн байдал г.м.) гол төлөв нууцлалтай байдаг. Нууцлалыг, ил тод байх, мэдээллийн эрх чөлөөний зарчимтай тэнцвэртэй хэрэглэх нь зүйтэй.




### CONFINTIATY

The requirement for public officials not to disclose to any member of the public, either orally or in writing, any secret or confidential information acquired by virtue of their public position. Most government information relating to the delivery of programs and services is public information. Confidential information is a small portion of total government information and it often relates to military, trade, technology or public bidding matters. Personal data (for example information on revenues and taxes to be paid by citizens) are usually also kept confidential. The need for confidentiality must be balanced against the principle of transparency and right of access to information.

*Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг*

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ДААТГАЛ



Улс орнуудын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн хариуцлагын даатгалын талаарх хууль эрх зүйн зохицуулалт, даатгалын үнэлгээ, хураамж, нөхөн төлбөрийн мэдээлэл дараах байдалтай байна. Үүнд:

**Америк** улсын хувьд мэргэжлийн хариуцлагын тусгай төрөл болох энэхүү эмч, эмнэлгийн ажилтны хариуцлагын даатгалд өвчтөний гэмтэл, үхэлд хүргэсэн маргаантай үйлчилгээний улмаас үүссэн хариуцлагыг даатгадаг. Америк улсын эмч нарын дийлэнх нь ажил мэргэжлийнхээ явцад дор хаяж нэг удаа ажил мэргэжлийн алдаа гарган, буруутай үйл ажиллагаатай тулгардаг байна. Энэ төрлийн даатгалд хамрагдах нь эмч нарт зайлшгүй шаардлагатай бөгөөд 51 мужийн 12 мужид уг даатгалд заавал даатгуулахыг шаарддаг. Ингэхдээ хуулийн шаардлага доод үнэлгээг тогтоох байдлаар маш товчхон байдаг. Өөрөөр хэлбэл эмч тухайн мужид ажиллахыг хүсвэл доод тал нь нэг хүнд 500,000 ам.доллараас багагүй, тохиолдол бүрд 1,500,000 ам.доллараас багагүй үнэлгээтэй мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдах ёстой. Үнэлгээг нэмэгдүүлэх эсэхийг эмч өөрөө шийддэг бөгөөд энэхүү даатгалд хамрагдаагүй тохиолдолд дадлага хийх эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах боломжтой. Харин шүдний эмч, сэтгэл зүйч, эм зүйч, нүдний эмч, сувилагч, физик эмчилгээний эмч нар уг даатгалд заавал хамрагдах шаардлагагүй ч энэхүү даатгалыг анхаарах шаардлагатай байна. Мөн АНУ-ын Ахмадын хэрэг эрхлэх газар (/U.S. Department of Veterans Affairs/) гэх мэт агентлагуудад ажилладаг эмнэлгийн мэргэжилтнүүд энэхүү даатгалд заавал хамрагдах шаардлагагүй байдаг байна.

**Итали** улсын хувьд 2014 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн эмч, эмнэлгийн ажилтнуудыг эмнэлгийн буруутай үйл ажиллагааны улмаас өвчтөнд учирсан хохирлыг барагдуулах зорилгоор мэргэжлийн буруутай үйл ажиллагааны хариуцлагын даатгалд хамруулахаар болсон. Энэхүү үүрэг нь Үндэсний эрүүл мэндийн албаны эмч, эмнэлгийн ажилтнуудад (төрийн албан хаагчид) хамаарахгүй байдаг байна. Харин ерөнхий эмчийн хувьд зөвхөн төрийн албан хаагчаар ажилладаг байсан ч зөвхөн хайхрамжгүй хандсан тохиолдолд баталгаа гаргахад

чиглэсэн даатгалд хамрагдах боломжтой бөгөөд даатгалын хураамж нь жилд 500–600 еврогийн үнэтэй байдаг бөгөөд даатгалд хамрагдаагүй бол сахилгын шийтгэл ногдуулдаг.

**Орос** улсын мэргэжлийн хариуцлагын даатгал нь сайн дурын үндсэн дээр явагддаг бөгөөд эмнэлгийн ажилчид ОХУ–ын Нийгмийн эрүүл мэндийн үндсэн зарчмуудын тухай холбооны хуульд заасан мэргэжлийн хариуцлагын аливаа эрсдэлийг даатгуулах эрхтэй байна.

**Сингапур** улсын эмч, эмнэлгийн ажилчдын хариуцлагын даатгал нь мөн адил сайн дурын даатгал бөгөөд эмч, эмнэлгийн ажилтны ажил мэргэжлээ гүйцэтгэх явцад санамсаргүй, буруутай үйл ажиллагааны улмаас эмчлүүлэгчийн өмнө хүлээх хариуцлага болон хуулийн хариуцлага, шүүхийн зардал, учирч болзошгүй хохирол, төлбөр тооцооноос хамгаалах боломжтой байдаг ба даатгалын тохиолдол гарахад өөрөө буюу хууль ёсны төлөөлөгч нь хохирлоо нэхэмжлэх эрхтэй байдаг.

Дээрх улс орнуудын туршлагаас харахад эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний ажил мэргэжлийн үйл ажиллагааны улмаас үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд гэм хор учрахад холбогдох санхүүгийн эрсдэлээс хамгаалах хариуцлагын даатгалын зохицуулалтыг улс орон бүр өөр өөрийн онцлогт тохируулан бий болгосон байна.

Харин манай улсын хувьд энэхүү даатгал нь сайн дурын буюу Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 207 дугаар тогтоолоор баталсан “Сайн дурын даатгалын хэлбэр”–ийн 1.10–т заасан “Хариуцлагын даатгал”–ын хэлбэрт хамаарч байна. Одоогоор даатгалын 5 компани эмч, эмнэлгийн ажилтны хариуцлагын даатгалын бүтээгдэхүүн, даатгалын 11 компани байгууллагын хариуцлагын даатгалын бүтээгдэхүүнийг тус тус Хороонд бүртгүүлсний үндсэн дээр зах зээл дээр түгээж байна. Даатгалын компаниуд нь эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх буюу оношилгоо, эмчилгээ, асаргаа сувилгаа, эмийн бэлдмэлийг сонгох, жор бичих явцад гаргасан мэргэжлийн алдааны улмаас эмчлүүлэгчийн эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлээс, харин байгууллагын хариуцлагын даатгалын хувьд үндсэн үйл ажиллагааны явцад гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах эрсдэлийг даатгаж байна.

Эрүүл мэндийн байгууллага болон эмнэлгийн мэргэжилтний хариуцлагаас үүдэн эмчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд түүнийг нотлох, хохирогч болон хохирлын хэмжээг тогтоож, шүүхээр шийтгэгдэх

хүртэлх цаг хугацаа ихээхэн шаарддаг бөгөөд энэ хугацаанд үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал хүлээх боломжгүй, цаг хугацаа алдаж өвчин эмгэг нь хүндрэх улмаар хохирлын хэмжээ улам нэмэгдэх нөхцөл байдал үүсдэг байна.

Цөөн статистик дурдвал, 2023 оны жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн яаманд иргэдээс нийт 5,200 гаруй өргөдөл, гомдол ирүүлсний 36.5 хувь нь эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой, 9.4 хувь эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой асуудлаар хандсан байна.

Иймээс манай улсын хувьд эрүүл мэндийн байгууллага болон эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагааны алдаа, зөрчил, эрсдэлээс үүдэн эмчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд гэм хор учрах үед холбогдох эрсдэлийг даван туулахад туслах зорилгоор эмнэлгийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих нарийвчилсан зохицуулалтыг хууль болон журмаар бий болгох шаардлагатай. Энэхүү хариуцлагын даатгалын зохицуулалтыг бий болгосноор эмнэлгийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн буруутай үйл ажиллагааны улмаас үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд гэм хор учрахад хохирогчийг санхүүгийн аливаа эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой болно.

Үүнтэй холбоотойгоор, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/96 дугаар тушаалаар эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгал, эмч, ажилтнуудыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний эрсдэлийн даатгалд хамруулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл орж ажиллаж байгаа бөгөөд ажлын хэсгээс эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, шаардлагатай зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах чиглэлээр ажиллаж байна.

Мөн энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс эрүүл мэндийн салбар дахь хариуцлага болон эмнэлгийн мэргэжилтний амь нас, эрүүл мэндэд учирч болох эрсдэлүүдийг хамгаалсан, олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүнийг зах зээл дээр бий болгох чиглэлээр даатгалын салбарын оролцогчдыг оролцуулсан дэд ажлын хэсгийг байгуулан холбогдох судалгаа хийж хамтран ажиллаж байна.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### “МОНГОЛЫН БАНКНЫ ФОРУМ” АРГА ХЭМЖЭЭ НЬЮ-ЙОРК ХОТНОО АНХ УДАА БОЛЛОО



АНУ-ын Нью-Йорк хотноо болж буй “Монголын хөрөнгө оруулалтын долоо хоног” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Монголын банкны форум” арга хэмжээ зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Сангийн яамны удирдлагууд, банк, санхүүгийн салбарын төлөөллүүд болон гадаадын хөрөнгө оруулагчид, шинжээчид оролцож, хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан форумыг нээж хэлсэн үгэндээ сүүлийн жилүүдэд Улсын их хурал, Засгийн газар болон зохицуулагч байгууллагын зүгээс авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүд, ялангуяа банкны салбарын реформын үр дүн буюу системд нөлөө бүхий банкууд дотоодын хөрөнгийн бирж дээр IPO хийж, нээлттэй хувьцаат компани болсон нь хөрөнгийн зах зээлийн өсөлт хөгжилд томоохон нөлөө үзүүлж байгаа талаар онцлон дурдсаны зэрэгцээ цаашид энэ салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, тэдэнд үйл ажиллагаа, өсөлтийн боломжоо таниулах нь чухал болохыг өгүүлсэн юм.

Форумд гадаадын 50 гаруй хөрөнгө оруулагч, шинжээч тэр дундаа BNP Paribas, JP Morgan, Morgan Stanley, Standard Chartered Banks, Moody's Rating Agency, Fitch Rating Agency зэрэг АНУ-д төвтэй томоохон банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын сангууд оролцсон бөгөөд энэхүү арга хэмжээ нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын зах зээлтэй холбох гүүр болох, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой боллоо.

### НЬЮ-ЙОРКИЙН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗЛАА



“Монголын хөрөнгө оруулалтын долоо хоног” нэгдсэн арга хэмжээ АНУ-ын Нью-Йорк хотноо энэ өдрүүдэд болж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанк, Сангийн яамны удирдлагууд, банк, санхүүгийн салбарын төлөөлөл, гадаадын хөрөнгө оруулагчид, шинжээчид оролцож байна. Энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан тэргүүтэй Монгол Улсаас оролцож байгаа төлөөлөгчдийг Нью-Йоркийн хөрөнгийн биржийн дэд ерөнхийлөгч Крис Тэйлор, Олон улсын асуудал эрхэлсэн газрын тэргүүн Уилл Гүдвин нар хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, сүүлийн жилүүдэд энэ зах зээлийг хөгжүүлэх, багтаамжийг нь нэмэгдүүлэх хүрээнд УИХ, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, реформуудын талаар Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан танилцуулаад цаашид хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд дотоодын компаниудыг тус хөрөнгийн бирж дээр гарах мөн уг биржийг Монгол Улсын хөрөнгийн зах зээлтэй хэрхэн холбох боломжийн талаар санал солилцсон юм.



## АНУ-Д СУУГАА МОНГОЛЧУУДАД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭВ



Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Голомт капитал ҮЦК” ХХК-ийн төлөөллүүд АНУ-ын Вашингтон, Чикаго хотноо ажиллаж, амьдарч буй монголчуудтай уулзалт хийж, хөрөнгийн зах зээлийн талаар мэдээлэл хүргэлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан уулзалтыг нээж УИХ, Засгийн газраас хэрэгжүүлж буй “Зээлийн хүүг бууруулах стратеги”, банкны салбарын реформ, төрийн өмчит компаниудыг олон нийтийн болгох зэрэг томоохон арга хэмжээний хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран санхүүгийн зах зээл тэр дундаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд хэрэгжүүлсэн онцлох ажлуудынхаа талаар танилцуулсан юм.

СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн мөн энэ үеэр Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, онцлох үйл явдлууд, ирээдүйн төлөв байдал зэрэг хөрөнгийн зах зээлийн талаарх ерөнхий мэдээллийг танилцуулав. Мөн иргэд сонирхсон асуултдаа хариулт авч, хөрөнгийн зах зээлээр дамжуулан хөрөнгө оруулалт хийх боломж, давуу талын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авсан юм.

## АНУ-ЫН ҮНЭТ ЦААС БИРЖИЙН ХОРОО /SEC/-НЫ ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, АНУ-ын Үнэт цаас биржийн хороо /SEC/-ны Олон улсын

харилцааны газрын Техникийн туслалцаа, хууль эрх зүй, төлөвлөлтийн хэлтсийн дэд захирал Paul Gum-agaу, тус хэлтсийн ахлах зөвлөх Jennifer Hardy нартай албан уулзалт хийлээ. Уулзалтаар Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны талаар болон Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын томоохон арга хэмжээний талаар танилцуулав. Мөн хөрөнгийн зах зээлийг улам тэлж, гадаадын хөрөнгө оруулагчдыг татахын тулд гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг нэмэгдүүлж, олон улсын зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх талд онцгой анхаарч ажиллаж байгааг онцоллоо. Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос санаачлан хэрэгжүүлж буй Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг Ази, Номхон далайн орнуудын хөрөнгийн зах зээлтэй холбох, гадаадын хөрөнгө оруулагч нарт сурталчлах, олон улсын зах зээлээс хөрөнгө босгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор цуврал арга хэмжээг олон улсын зохицуулагч байгууллагуудтай хамтран зохион байгуулж байгаа талаар танилцуулсан юм.



Энэ хүрээнд хоёр орны зохицуулагч болон дэд бүтцийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах хүрээнд хамтран ажиллах, тус улсын хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд оролцох идэвх сонирхлыг нэмэгдүүлэх хүрээнд дотоодын компаниудыг АНУ дахь хөрөнгийн биржүүд дээр давхар бүртгүүлэх боломжийг бий болгох чиглэлээр санал солилцлоо. Мөн АНУ-ын Үнэт цаас биржийн хороо/SEC/-ны зүгээс Санхүүгийн зохицуулах хорооноос санаачлан хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, хяналт шалгалтыг сайжруулах хүрээнд албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхээр сургалт зохион байгуулах зэргээр дэмжлэг үзүүлэхээр боллоо.

## “САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО” ХЭНТИЙ АЙМГААС ЭХЭЛЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Санхүүгийн зах зээлийн хөгжил ба иргэдийн оролцоо” сургалт хэлэлцүүлэг, өдөрлөгийг орон нутгуудад уламжлал болгож зохион байгуулдаг бөгөөд энэ жилийн нэгдсэн арга хэмжээг Хэнтий аймгаас эхлүүлж Чингис хотын “Хан хэнтий чуулга”-ын хурлын танхимд нээлтээ хийлээ.

Сургалт, хэлэлцүүлгийн үеэр хөрөнгийн зах зээлийн бодлого зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал, зохицуулалтад шинээр ороод буй уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрхзүйн орчин, зах зээлийн нөхцөл байдал мөн даатгалын салбарын хууль эрхзүйн орчны шинэчлэлт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, иргэд, олон нийтэд тулгардаг нийтлэг асуудал, санхүүгийн залилан, луйвраас хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл хүргэлээ. Түүнчлэн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, банк, үнэт цаас болон даатгалын компаниуд, банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөл оролцож бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулан иргэдэд үнэт цаасны данс нээж, хэрхэн хувьцаа эзэмшигч хэрхэн хувьцаа эзэмшигч болох талаар зөвлөгөө мэдээлэл өглөө.

## ИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦЛЭЭ

ИХ-ын Эдийн засгийн байнгын хороо /ЭЗБХ/-ны өнөөдрийн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ. Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун үйл ажиллагааны



тайланг танилцуулсан бөгөөд хороо өнөөдрийн байдлаар 11 салбарын 6182 зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд зохицуулалт, хяналт тавьж ажиллаж байна. Салбарын зарим онцлох ажлаас дурдвал банкны салбарын реформ амжилттай хэрэгжиж 478.5 тэрбум төгрөгийг 72 мянга гаруй хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн бол уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт 299 удаагийн дуудлага худалдаагаар 7.5 их наяд төгрөгийн арилжаа явагдсан байна. Үүний зэрэгцээ хөрөнгө оруулалтын сангийн багц журамд биржээр арилжаалдаг хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг тусгаснаар хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж бүрдэж, хөрөнгө оруулагчид шинэ төрлийн бүтээгдэхүүн авах,



олон улсын томоохон компаниудын хувьцааны өгөөжийг сангаараа дамжуулан хүртэх боломж бий болсон. Мөн анх удаа ногоон бонд гарч “Ногоон бондын санхүүжилтийн хүрээ”-нд тодорхойлсон төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх 17 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татсан. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор нэр бүхий таван журмыг

баталж зохицуулалтын орчинг бүрдүүлснээр одоогийн байдлаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх 42 хуулийн этгээдийг бүртгээд байгаа талаар мэдээлэл өглөө.

Мөн УИХ, Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж буй “Зээлийн хүүг бууруулах стратеги”, банкны салбарын реформ, төрийн өмчит компаниудын хувьчлал зэрэг томоохон шинэчлэлийн хүрээнд хөрөнгө оруулагчдыг дэмжсэн эрх зүйн орчин бүрдсэнээр энэ жилээс гадаадын хөрөнгө оруулагчдын албан татварт ногдох орлогыг дотоодын хөрөнгө оруулагчтай ижил тэнцүү, ялгаваргүй байдлаар суутган тооцох, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдаас үл хамааран үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024–2026 онд 90 хувь, 2027–2029 онд 50 хувиар хөнгөлөх зохицуулалт бий болсон. Түүнчлэн Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын түвшинд гаргах, Ази, Номхон далайн орнуудын хөрөнгийн зах зээлтэй холбох, дотоодын компаниудыг гадаадын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг гаргах, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор “Mongolia’s Capital Market Connectivity Hong Kong”, “Shanghai” цуврал арга хэмжээг зохион байгуулсан болон санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээнийхээ талаар танилцуулав. Тайлантай холбоотойгоор ЭЗБХ-ны гишүүн Ч.Ундрэм, О.Цогтгэрэл нар даатгалын хураамж, үйлчилгээ, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын засаглал, ил тод байдал, финтекийн зээлийн бүтээгдэхүүний талаар тодруулга авсан юм.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН ХАВРЫН ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ

АНУ-ын Вашингтон хотноо Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн хаврын чуулга уулзалтад Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан оролцлоо. Чуулга уулзалтад улс орнуудын төв банк, санхүүгийн зохицуулагч байгууллага болон төр, хувийн хэвшлийн санхүү, бизнесийн салбарын төлөөллүүд оролцож олон улсын санхүү, эдийн засгийн сэргэлт, Дэлхийн банкны Хөгжлийн хороо, Олон улсын валютын сангийн Валют, санхүүгийн хорооны жилийн тайлан, энэ оны ажлын төлөвлөгөөний явцын талаар хэлэлцэв. Энэхүү чуулга, уулзалтын үеэр зохион байгуулагдаж буй Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн “Төр ба хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалт” болон “Жи24-ийн дугуй ширээний уулзалт”-д мөн тэрбээр оролцов.

Олон улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн “Төр ба хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалт”-д нийгэмлэгийн гишүүн төв банкууд, санхүүгийн зохицуулагч байгууллагуудын удирдлагууд болон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд тэргүүлж буй хувийн хэвшлийн захирлууд оролцож “Хүртээмжтэй ногоон санхүүжилт”-ийн хүрээнд сайн туршлага, анхаарах асуудлын талаар



санал солилцов. Мөн энэ үеэр өнгөрсөн оны “Хүртээмжтэй ногоон санхүүжилт” стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулж, дүгнэсэн бөгөөд гишүүн орнууд ногоон санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүнгийнхээ талаар танилцуулав. Харин “Дэлхийн уур амьсгалын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд болсон “Жи24-ийн дугуй ширээний уулзалт”-аар уур амьсгалын санхүүжилтийн шинэ стандартуудыг боловсруулах, үүнийгээ санхүү, хөрөнгийн бодлого тодорхойлогч олон улсын байгууллагуудын үйл ажиллагаатай хэрхэн уялдуулах талаар хэлэлцэв.

## БАЙР СУУРЬ

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ

**Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга Ц.Алтантуултай салбарын эрх зүйн орчны шинэчлэлийн талаар ярилцлаа.**

**Танд энэ өдрийн мэнд хүргэе. Хадгаламж, зээлийн хоршооны хууль эрх зүйн орчны шинэчлэлийн талаар мэдээлэл өгөхгүй юу?**

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг Улсын Их Хурлаас 2011 онд баталсан. Түүнээс хойш 2015 онд Зөрчлийн тухай хууль, 2022 онд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, 2023 онд Зөвшөөрлийн тухай хуультай холбоотой нэмэлт өөрчлөлт орсноос өөрөөр өөрчлөлт ороогүй. Тасралтгүй хөгжиж байгаа зах зээлийн чиг хандлагад нийцсэн, гишүүддээ зориулсан үйлчилгээ бүхий салбарыг хөгжүүлэх эрх зүйн орчин, зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлага байгаа. Энэ үүднээс Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсруулж 2023 онд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн.

**Хуулийн өөрчлөлтийн гол концепци юу вэ?**

Хадгаламж, зээлийн хоршоо нь харилцан туслалцах зарчим дээр тулгуурлан байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулдаг. Санхүүгийн үйлчилгээг зөвхөн гишүүддээ хүргэж, гишүүд нь хоршооныхоо үр өгөөжийг хүртдэг учраас энэ салбар бүс нутгийн хөгжил болон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үйл ажиллагааг тогтвортой, найдвартай, амжилттай явуулах суурийг сайн засаглал, гишүүдийн ардчилсан удирдлага, хамтын хяналт бүрдүүлэхээс гадна гишүүддээ зориулсан бүрэн үйлчилгээтэй хадгаламж, зээлийн хоршоодыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тогтолцоо хэрэгтэй. Хадгаламж, зээлийн хоршооны зах зээлийн найдвартай байдал болон хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалахын тулд дэлхийн улс орнууд хамгаалалтын 2–3 давхарга бүхий тогтолцоог бий болгон ирсэн бөгөөд эдгээр тогтолцоог нэвтрүүлэх улс орны тоо тогтмол өсөж байгаа нь энэ төрлийн хамгаалалт санхүүгийн тогтвортой байдлыг хангахад, үндэсний хэмжээнд санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд нэмэртэй байгааг харуулж байна. Энэхүү тогтолцоонд, нэгдүгээрт, хадгаламж, зээлийн хоршоодын цэвэр орлогоос байгуулдаг нөөцийн сан, хоёрдугаарт, үйл ажиллагааны түр хугацааны хүндрэлд орсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар алдагдсан хадгаламж, зээлийн хоршоодод мэргэжил арга зүйн болон санхүүгийн туслалцаа үзүүлж, дампуурахаас сэргийлж үйл ажиллагааг сэргээхэд чиглэдэг тогтворжуулалтын сан, гуравдугаарт, хадгаламжийн даатгал бөгөөд хадгаламж, зээлийн хоршоо дампуурсан тохиолдолд даатгагдсан хадгаламжийг хадгаламж эзэмшигчдэд нөхөн олгодог тогтолцоо.

**Одоо хэрэгжиж байгаа дүрэм, журмуудад өөрчлөлт орсон уу?**

Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулахаар бэлтгэж байна. Шалгуур үзүүлэлтийг олон улсын түвшин рүү дөхүүлэх, хоршоодын үйл ажиллагааг илүү эрүүлжүүлж, урт хугацааны хөгжлийг бататгах

зорилготой. Мөн бид хадгаламж, зээлийн хоршооны хяналт шалгалтыг улам сайжруулж, боловсронгуй болгох чиглэл рүү явж байгаа. Ингэснээр хяналт шалгалтыг илүү үр дүнтэй боловсронгуй болгохоос гадна, нөөц хэмнэх боломж бүрдэнэ.

2024 он гарснаар бид Сангийн яамтай хамтран Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн журмыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, Сангийн сайдаар батлууллаа. Мөн шинээр Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаалаар хадгаламж, зээлийн хоршооны дотоод хяналтын шалгах хуудсыг зөвлөмж хэлбэрээр баталсан. Энэ нь хадгаламж, зээлийн хоршооны хяналтын зөвлөлийн хийх дотоод хяналтыг илүү тодорхой болгож, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлтэй үйл ажиллагааг олж илрүүлэх, бууруулах, арилгахад хадгаламж, зээлийн хоршоог чиглүүлнэ.

**Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын чиглэлээрх сүүлийн үеийн өөрчлөлтөөс дурдвал?**

Хадгаламж, зээлийн хоршоодыг зээлийн батлан даалтын санд хамруулах ажил сүүлийн үед идэвхтэй урагшилж байна. Эхний ээлжид 4 хадгаламж, зээлийн хоршоон дээр батлан даалтын үйл ажиллагааг нэвтрүүлж туршихаар бэлтгэл ажлыг хангасан. Зээлийн батлан даалтын санд хадгаламж, зээлийн хоршоод хамрагдсанаар хоршооны гишүүн барьцаа хөрөнгийн дутагдалтай бичил, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломж нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлтэд ч эерэгээр нөлөөлнө.

**Хадгаламж, зээлийн хоршооны салбарт ямар төсөл хэрэгжиж байгаа вэ?**

Азийн хөгжлийн банктэй хамтарсан “Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө Зүүн Азид жендэрийн тэгш байдлыг эрчимжүүлэх” төсөл 2022 оноос хэрэгжиж байна. Төслийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр “Жендэрийн мэдрэмжтэй ногоон санхүүгийн хувьсал дахь хадгаламж, зээлийн хоршоодын оролцоо” хэлэлцүүлгийг зохион байгуулж хадгаламж, зээлийн хоршоодод жендэрийн мэдрэмж бүхий ногоон санхүүжилтийн үзэл баримтлал, зарчмууд, тогтвортой хөгжлийн зорилтууд болон уур амьсгалын өөрчлөлтийн амлалтуудын талаар ойлголт, мэдээлэл өгсөн. Мөн хадгаламж, зээлийн хоршооны салбарт жендэрийн мэдрэмжтэй ногоон зээлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх олон улсын туршлага болон төслийн хүрээнд хийсэн судалгааны үр дүнг танилцуулж, олон улсын туршлагыг нэвтрүүлэх боломж, шийдлийн талаар хэлэлцсэн. Цаашид жендэрийн мэдрэмжтэй ногоон санхүүжилтийн хувьд тэдний ахиц дэвшил, ололт амжилтыг хянах, үнэлэх, тоон болон чанарын мэдээлэл, нийгэм, байгаль орчны үр дүнг агуулсан шалгуур үзүүлэлт, аргачлалыг ашиглах шаардлага тулгарч байгаа. Иймд эхний ээлжид дата мэдээллээ цуглуулах зорилгоор хадгаламж, зээлийн хоршоодоос авдаг тайлангийн маягтад хүйсээр ангилсан болон ногоон зээлийн мэдээллийн хэсгийг нэмж тусгаж байна.

**Ярилцсанд баярлалаа. Танд ажлын амжилт хүсье.**

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## МОНГОЛЫН ТЕКСТИЛИЙН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### ТоС Холбооны Монголын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн судалгааны хэсгээс

Текстилийн салбар нь МУ-ын ДНБ болон нийт ажлын байрны багагүй хувийг бүрдүүлдэг хэдий ч тогтворгүй, хяналтгүй түүхий эд бэлтгэл, түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийн үр ашиггүй байдал, олон улсын зах зээлд гарахад учирдаг баталгаажуулалт, шошгожуулалттай холбоотой асуудлууд зэрэгт эмзэг өртөмтгий байна. Зах зээлийн эдийн засгийн шилжилт нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчдын эмзэг, өртөмтгий байдлыг улам нэмэгдүүлсэн. Малын тоо толгойн хэт их өсөлт, хувьчлалын үр дагавар зэрэг нь хэд хэдэн байгаль орчны асуудлууд тэр дундаа бэлчээрийн доройтол, цөлжилтийг бий болгоход ихээр нөлөөлж байна.

Монголын текстилийн салбараас ялгарах Хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ын хэмжээ, усны өндөр хэрэглээ нь Ази тив дотроо хамгийн өндөрт тооцогдох бөгөөд хаягдал усны менежментийн асуудал тун сул байна. Ноос ноолуур угаах, боловсруулах үйлдвэрлэлүүд ихээр төвлөрсөн Улаанбаатар хотод эрчим хүчний хомсдол, ундны цэвэр усны асуудлууд үүсэж эхэлсэн бөгөөд 2025 он гэхэд усны ноцтой хомсдол үүсэх тухай судалгааны үр дүнгүүд гарсаар байгаа тул тус салбар нь байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийн арга туршлагыг салбарын хэмжээнд, ойрын хугацаанд нэвтрүүлэх шаардлагатай. Монголын текстилийн бичил, жижиг дунд үйлдвэр (БЖДҮ)-үүд нь байгаль орчин, нийгмийн удирдлага сайжруулах хүсэл тэмүүлэлтэй байгаа хэдий ч одоогийн нөхцөл байдал, байгаль орчин, нийгэм (БОН)-ийн асуудлуудыг таньж тогтоох, шийдвэрлэх талаарх мэдлэг хомс байна.

Ногоон хөгжлийн гол бүрэлдэхүүн хэсэг нь тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл юм. Гэвч ногоон үйлдвэрлэл ба хэрэглээний арга хэмжээ төдийлөн сайн хэрэгжихгүй байгаа шалтгаануудын нэг бол иргэд, үйлдвэрлэгчид ногоон руу шилжих шилжилтийг зардал өндөртэй, ихээхэн төсөв хөрөнгө шаардана хэмээн үзэж байгаа явдал юм. Харин энэхүү нийгэмд тогтсон чиг хандлагыг эвдэж, эдийн засгийн ногоон шилжилтийг хүртээмжтэй, зардал багатай хийх арга бол тогтвортой, ногоон санхүүжилт юм.

### Текстилийн салбарт яагаад ногоон санхүүжилт хэрэгтэй вэ?

- ◆ Нөхөн сэргээгдэх баялаг, стратегийн ач холбогдол бүхий түүхий эд, нөөц;
- ◆ Цогцолбор үйлдвэрүүдийг хөгжүүлэх үндэсний бодлого, хөтөлбөрүүд;
- ◆ Текстилийн салбар нь бохирдуулагч, нүүрстөрөгчийн ул мөр өндөртэй;
- ◆ Худалдан авагч талаас ирж буй тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний өсөн нэмэгдэж буй шаардлага, эрэлт;
- ◆ Текстилийн БЖДҮ-үүдийн санхүүжилт авах боломж хязгаарлагдмал зэрэг шалтгааныг дурдаж болно.

Түүхий эд бэлтгэлээс эхлээд үйлдвэрлэлийн бүх үе шат нь байгальд ээлтэй, үйлдвэрлэлд ашиглагдаж буй машин, техник технологи нь ус, эрчим хүчний хэмнэлттэй, ашиглаж буй химийн бодис нь байгаль ба хүнд сөрөг нөлөөгүй, жөндөр, нийгмийн бодлоготой байхыг дэлхий даяар шаардаж, дэлхий нийтийн хэрэглээний хандлага өөрчлөгдөж байна.

2019 онд хийгдсэн Монголын текстилийн салбарын БЖДҮ-лэгчдийн ногоон санхүүжилтийн зах зээлийн эрэлтийн судалгаанаас үзэхэд нийт текстилийн салбарын ЖДҮ-ийн ногоон санхүүгийн эрэлт зорилтот төсөөллөөр 576.0 орчим тэрбум төгрөг байна. Гэвч нөгөө талаас монголын нэхмэлийн салбарын ААН-үүдийн авах боломжтой ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн хэмжээ 75.0 тэрбум төгрөг гэсэн тооцооллол гарчээ.

Өөрөөр хэлбэл текстилийн ЖДҮ-ийн тогтвортой, ногоон үйлдвэрлэл рүү шилжих шилжилтийг хийхэд одоогийн боломжит эх үүсвэрээс 3.3–7.6 дахин их хэмжээний санхүүжилт шаардлагатай болох нь тодорхой байна. Ярилцлага, судалгаанд хамрагдсан, идэвхтэй үйл ажиллагаатай 17 үйлдвэрт 2019 оны 10 дугаар сарын байдлаар нийт 24.5 тэрбум төгрөгийн ногоон санхүүгийн эрэлт байсан бөгөөд тус эрэлтийн 10.7 тэрбум

төгрөг (44%) нь үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах шийдэлд, 4.41 тэрбум төгрөг (17%) нь бохир усны цэвэрлэх байгууламж барихад, үлдсэн 9.39 тэрбум төгрөг (21%) нь үйлдвэрлэл, үйлчилгээг ногоон, тогтвортой болгох бусад хэрэгцээнд шаардлагатай байна.

Нэхмэлийн үйлдвэрүүдийн хувьд ногоон санхүүд хамруулах боломжтой 42 нэр төрлийн зориулалтыг тодорхойлсон байна. Ногоон санхүүгийн хэрэгцээ мөнгөн дүнгээр цогцолбор үйлдвэрүүдэд хамгийн өндөр буюу 14.3 тэрбум төгрөг (58.2%), анхан шатны үйлдвэрүүдэд 8.2 тэрбум төгрөг (33.3%) харин сүлжмэлийн үйлдвэрүүдэд харьцангуй бага буюу 2.1 тэрбум төгрөг (8.4%) байна. Эдгээр ногоон санхүүгийн хэрэгцээ нь үйлдвэрлэлийн төрлөөс хамаарч ихээхэн хэлбэлзэж байна. Тухайлбал, цогцолбор үйлдвэрүүдийн хувьд дулааны хэмнэлттэй болох хэрэгцээ нь нийт ногоон санхүүгийн эрэлтийн 71.0 хувь, сүлжмэлийн үйлдвэрүүдийн хувьд 19.0 хувь, харин анхан шатны үйлдвэрүүдийн хувьд хамгийн бага буюу 3.0 хувьтай тус тус тэнцэж байна.

Цаашлаад анхан шатны үйлдвэрүүдийн хувьд ногоон санхүүгийн 30.0 орчим хувь нь цэвэрлэх байгууламжид төлөвлөгдсөн бол сүлжмэлийн үйлдвэрүүдийн хувьд ажилчдын нийгмийн асуудлыг сайжруулах, эко сав баглаа боодолтой болох, хог хаягдлын менежментийг бий болгох,

сайжруулах, үйлдвэрлэлийн хүчин чадлаа илүү ногоон дэвшилтэт технологи ашиглан өргөжүүлэх сонирхол, шаардлага 50.0 орчим хувийг эзэлж байна.

Үндсэн 7 чиглэлийн хүрээнд нийт 42 нэр төрлийн ногоон санхүүгийн хэрэгцээ байгааг тогтоосон бөгөөд эдгээр нь хамгийн чухал зориулалтын нэр төрлүүд юм. Цахим асуулга болон ярилцлага судалгаа аль алинд хамрагдсан үйлдвэрүүд ногоон санхүүгийн хэрэгцээгээ гаргахдаа өөр өөр дүнгүүд тооцоолж өгсөн бөгөөд цахим асуулгаар тодорхойлсон ногоон санхүүгийн хэрэгцээт хэмжээ ярилцлага хийх замаар цуглуулсан дүнгээс ямагт өндөрт байгаа юм.

Цахим асуулгад хариулахдаа үйлдвэрүүд шаардлагатай бусад санхүүжилтийн дүнг нэмж оруулсан эсвэл ногоон ангилалд багтахгүй хөрөнгө оруулалтын хэрэгцээг нэмж тооцсонтой холбоотой гэж үзээд нэхмэлийн салбарын ЖДҮ-үүдийн ногоон санхүүгийн нийт эрэлтийг тогтоохдоо ярилцлагад хамрагдсан 17 үйлдвэрийн бодит хэрэгцээнд үндэслэв.

2019 оны 3 дугаар улирлын байдлаар судалгаанд хамрагдсан 17 үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадал, зах зээлд эзлэх байр сууриар төлөөлүүлж тооцоод салбарын ногоон санхүүгийн эрэлт бодит төсөөллөөр нийт 250.0 тэрбум төгрөгтэй тэнцэнэ гэж тооцоолжээ.

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

## КОМПЛАЙНСЫН ЧИГ ХАНДЛАГА

Комплайнсын зохицуулалтын орчин 2024 онд хурдацтайгаар хөгжихийн зэрэгцээ энэхүү нарийн төвөгтэй төлөв байдлын орчин цагийн чиг хандлага нь компаниудын удирдлагын арга барилд бодитойгоор нөлөөлж байна. Үүнд дэлхий даяар хувьсан өөрчлөгдөж буй жишиг хэм хэмжээ, зохицуулагчдын өсөн нэмэгдэж буй хяналт болон технологийн ололт амжилтууд түлхэц өгдөг.

### Комплайнсын хөгжлийг 2024 онд тодорхойлж буй голлох 10 чиглэл:

**1 Мэдээллийн аюулгүй байдал**

Мэдээллийн нууцлал, аюулгүй байдалтай холбоотой зөрчлийн давтамж ихсэж байгаад онцлон анхаарч, түүнд хариу үйлдэл үзүүлэх талаар комплайнсын стратегид тусгаж, хамгаалалтын эрэмбэ тогтоох нь зайлшгүй ба баталгаажуулалт, зөвшөөрлийн үр дүнтэй арга хэрэгслийг нэвтрүүлэх шаардлагатай аж.

Түүнчлэн, улс үндэстнүүд мэдээлэл хамгаалах хууль тогтоомж, түүний нууцлалтай холбоотой шаардлагуудыг нэмэгдүүлэхийн хэрээр түүний хэрэгжилтийн чанарын түвшин анхаарал татаж байна.

**2 Хиймэл оюун ухаан**

Хиймэл оюун ухаан нь салбар бүрд компанийн үйл ажиллагаанд нөлөөлж, шинэ технологийн улмаас комплайнсын талбар ч эрс өөрчлөгдсөн.

Хиймэл оюун ухаанд суурилсан технологиуд нь мэдээлэл, өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг хурдасгаж, үйл ажиллагаанд эрс хувьсал хийх боломжийг олгосон бөгөөд их хэмжээний мэдээллийн багцыг үнэлэх замаар комплайнсын хяналтыг сайжруулах шаардлагатай асуудлыг тодорхойлоход тусалж байна. Үүнийг болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглах, тэдгээрийг удирдах тактик хэрэгжүүлэхэд ашиглах боломжтой.

**3 Тогтвортой байдал**

Хүрээлэн буй орчны тогтвортой байдлын төслүүдийг дэмжиж ажиллахыг компаниудад үүрэг болгож байгаа газар зүйн бүс нутгийн онцлогоос хамаарсан хүрээлэн буй орчинд ээлтэй, тогтвортой байдлын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх шаардлага үүссэн. Түүнчлэн, уг нөхцөл байдлаас улбаалан уур амьсгалын эрсдэлээ үнэлж, тайлагнахыг компаниудад үүрэг болгож байна.

**4 Кибер аюулгүй байдал**

Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс компаниуд эцсийн хэрэглэгч болон үүлэн тооцооллын технологид анхаарах үүднээс кибер аюулгүй байдлаа сайжруулах шаардлагатай болж байна. Үүний тулд кибер халдлагыг илрүүлж, хариу арга хэмжээ авах механизмыг бүрдүүлэх, халдлагыг илрүүлэх аюулгүй байдлын арга хэрэгслийг нэвтрүүлж, улмаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх арга замаа өөрчлөхөд хүрч байна.

**5 Үүлэн тооцоолол**

Үүлэн технологийн хөгжил хэвээр үргэлжилж байгаатай холбогдуулан түүний зохицуулалтын нөхцөл, шаардлагууд хэрэглэгчдийн хүлээлттэй зэрэгцэн нэмэгдэх төлөвтэй байна. Эдгээр шинэ зохицуулалтыг комплайнсын стратегидаа тусган, ашиглах нь чухал.

6

**Биет бус программ хангамж (SaaS)**

Биет бус программ хангамжийн удирдлага болон хэрэглэгчийн нууцлалтай холбоотой хууль тогтоомжийг чанд мөрдөх шаардлагатай. Биет бус программ хангамжийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчдийн хооронд хил дамнасан мэдээлэл дамжуулах хэрэгцээ нэмэгдэж байгаа нь үүний нэг жишээ юм.

8

**Зохицуулалтын орчны өөрчлөлт**

Ирэх жилүүдэд компаниудын хувьд дэлхий даяар гарч буй зохицуулалтын өөрчлөлтөд дасан зохицох, ялангуяа банк санхүү, технологи зэрэг салбаруудад эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах шаардлага үүсэж байна. Зарим компаниуд энэхүү өөрчлөлтийг даван туулж, бэлэн байхын тулд зохицуулалтын удирдлагын системээ сайжруулах шаардлагатай.

**Дүгнэлт**

Дэлхий даяар хувьсан өөрчлөгдөж буй жишиг хэм хэмжээ, зохицуулалтын өсөн нэмэгдэж буй хяналт, технологийн ололт амжилтаас улбаалан 2024 онд комплайнсын удирдлагын орчин нөхцөл хурдацтай өөрчлөгдөж байна.

Санхүүгийн байгууллагууд эдгээр тогтворгүй байдлыг амжилттай даван туулахын тулд алсын хараатай, урт хугацаандаа дээр дурдсан чиг хандлагуудад зохицсон стратегийг баримтлах хэрэгтэй юм.

Эх сурвалж: <https://www.linkedin.com/>

7

**Комплайнсын хяналтад ашиглах нээлттэй эх сурвалж**

Комплайнсын хяналтын үйл ажиллагаанд нээлттэй эх сурвалжийг ашиглах нь 2024 онд улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Иймд компаниуд комплайнсын хяналтын хөтөлбөртөө нээлттэй эх сурвалж, программ хангамжийг ашиглах эрхтэй холбоотой сөрөг үр дагавраас сэргийлэх төлөвлөгөөг тусгах шаардлагатай.

9

**Оролцогч талуудын эрсдэлийн удирдлага**

Компанийн оролцогч талуудаас хараат байдал нэмэгдэхийн хэрээр тэдгээрийн буюу борлуулагчид болон ханган нийлүүлэгчидтэй холбоотой эрсдэлийг судлах, нэгтгэх, удирдах нь чухал. Энэ нь эрсдэлийн удирдлагын стратегидаа ханган нийлүүлэлтийн сүлжээ, геополитик болон байгаль орчны асуудал зэргийг тусгаж, өргөжүүлэхийг шаарддаг.

10

**Үйл ажиллагааны уян хатан байдал**

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд чухал хүчин зүйл болох кибер халдлага зэрэг болзошгүй хямралын үед үйл ажиллагааны уян хатан байдлыг хадгалахын тулд бизнесийн тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөөтэй байх шаардлагатай. Үүний үр дүнд дүрэм, журмууд нь банк, санхүү зэрэг тодорхой салбарт үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, хяналт тавихад чиглэгдэнэ.



## ФИНТЕК БА РЕГТЕК

### 2024 ОНЫ ФИНТЕКИЙН ЧИГ ХАНДЛАГА

2023 онд финтекийн зах зээлийн үнэлгээ 226.0 тэрбум ам.долларт хүрч өндөр өсөлтийг үзүүлсэн. 2028 он хүртэл финтекийн зах жил бүр 16.8 хувиар өсөж 2028 он гэхэд зах зээлийн үнэлгээ 917.0 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байгааг шинжээчид онцолжээ. Дэлхий даяар бизнес эрхлэгчид финтекийн салбарыг сонирхох хандлага улам нэмэгдэж, санхүүгийн технологийн салбар илүү хөгжиж, бизнесийн орчинд финтек зах зээлийн хүрээ улам тэлсээр байна. Бид энэ удаа бизнес эрхлэгчдэд зориулан таны компанийг дараагийн шатанд гаргах 2024 оны тренд финтекийн 4-н шилдэг чиг хандлагыг танилцуулж байна.



Санхүүгийн өсөлт



Зохицуулалтын стандартын дижитал шилжилт



Банкны зохицуулалтыг хялбарчлах хандлага



Цахим мөнгө гаргагч байгууллагуудын зохицуулалтын орчныг нэмэгдүүлэх

#### 1. Угсармал санхүүгийн өсөлт

Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөөн нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчид санхүүгийн аюулгүй байдлыг хангасан, найдвартай санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг эрэлхийлж байна. 2024 оны финтекийн салбарын тэргүүлэх чиг хандлага нь “Угсармал санхүү” юм.

Ухаалаг утасны хэрэглээ, гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулах хандлага нэмэгдэхийн хэрээр угсармал санхүүгийн зах зээлийн өсөлтийг хурдасгах хандлага эрчимждэг. Дэлхийн угсармал санхүүгийн зах зээл 2028 он хүртэлх хугацаанд жил бүр 35.5 хувиар өсөх төлөвтэй байна.

Угсармал санхүү болон зөвшөөрөлтэй банкнууд дижитал банкны үйлчилгээгээ бусад банк бус бизнесүүдийн бүтээгдэхүүнтэй нэгтгэн үйлчилгээ үзүүлэх загвар “BaaS (Banking-as-a-Service)” нь

уламжлалт санхүүгийн зуучлагчдын санхүүгийн зах зээлийн оролцоог улам бүр хумьж байна.

Угсармал санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид санхүүгийн зах зээлийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг дахин тодорхойлж төрөл бүрийн платформ, программуудтай шууд нэгдэх боломжийг бизнес эрхлэгчдэд олгох бүтээгдэхүүн, үйлчилгээг туршсаар байна. Мөн хэрэглээний программын интерфэйс “API” нь санхүүгийн болон санхүүгийн бус брэндүүдэд санхүүгийн үйлчилгээг өөрсдийн вэбсайт, платформ, мобайл аппликейшнд шууд нэгтгэх боломжийг олгоход чухал үүрэг гүйцэтгэж байна.

Угсармал санхүү нь санхүүгийн үйлчилгээг санхүүгийн бус платформтой уялдуулан нэгтгэж, бизнесүүдэд технологид суурилсан шинэлэг үйлчилгээг санал болгох, хэрэглэгчид өөрсдийн дуртай платформоосоо гарахгүйгээр санхүүгийн бүтээгдэхүүнд хандах

боломжийг олгодог. Хэрэглэгчид амар хялбар өөрт таатай байдлаар санхүүгийн үйлчилгээ авах хэрэгцээ шаардлага байдаг бол бизнес эрхлэгчид мөнгө олох шинэ боломжуудыг эрэлхийлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд угсармал санхүүжилт чухал дэмжлэг үзүүлэх, амжилттай бизнесийн загварыг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

## 2. Зохицуулалтын стандартын дижитал шилжилт

Улс орнуудын зохицуулагч байгууллагууд дижитал санхүүгийн өнөөгийн эрсдэлийг тооцоолох, эрсдэлийг удирдах технологийн шийдлийг нэвтрүүлэхийг зорин ажилладаг. Финтек болон бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид зохицуулалтын шинэ стандартуудыг дагаж мөрдөхийн тулд стандартын шилжилтийг цаг алдалгүй хийж шилжилтийн үед дасан зохицох шаардлагатай байна. Жишээ нь Европт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгч зохицуулалтуудын шинэ стандарт болох Крипто-Хөрөнгийн зах зээлийн зохицуулалт (MiCA), төлбөрийн үйлчилгээний заавар v3.0 (PSD3), Европын комиссын eIDAS журам, цахим нэхэмжлэхийн Европын стандартуудыг нэвтрүүлэх шаардлагатай. Харин Испанид үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчид 2026 онд хэрэгжиж эхлэх зээлийн дүрмийн өөрчлөлтийг нэвтрүүлэх шаардлагатай. Учир нь Испанид 2026 онд цахим нэхэмжлэхийг заавал дагаж мөрдөх шинэ "Crea y Crea" зохицуулалт бий болох юм.

## 3. Банкны зохицуулалтыг хялбарчлах

Жижиг бизнесүүдийн хувьд финтек нь санхүүгийн болон банкны сорилтуудыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Банкны үр ашигтай зохицуулалт нь бизнес эрхлэгчдийн хамгийн чухал хэрэгцээний нэг юм. Хэрэглээний программын интерфейс "API"-ийн тусламжтайгаар банкны зохицуулалтыг автомат системээр хялбаршуулж, бизнес эрхлэгчдэд API-г нягтлан бодох бүртгэлийн системтэйгээ хялбархан нэгтгэх боломжийг олгодог.

Мөн API нь компанийн санхүүгийн системийг сайжруулж, гар аргаар нэгтгэх үйл явцад зарцуулсан нийт цаг хугацаа, нөөцийн зардлыг багасгах боломжийг олгодог.

## 4. Цахим мөнгө гаргагч байгууллагуудын зохицуулалтын орчныг нэмэгдүүлэх

2024 онд финтекийн салбарт мэдээллийн нууцлал, кибер аюулгүй байдал, санхүүгийн үйлчилгээний зохицуулалтын хөгжилд онцгой анхаарал хандуулах шаардлага тулгараад байна. Цахим мөнгө гаргагч хуулийн этгээд "EMI"-д итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх хамгийн сайн шийдэл бол хамгийн сүүлийн үеийн зохицуулалтын чиг хандлагад маш хурдан хариу үйлдэл үзүүлэх чадвартай технологид хөрөнгө оруулах явдал юм. Ингэснээр илүү оновчтой стратегийг бий болгох, зохицуулалтын орчныг сайжруулах боломжтой.

Эх сурвалж: <https://www.unnax.com/fintech-trends-2024/>

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ЗЭСИЙН ҮНЭД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

#### Гүйцэтгэсэн:

Санхүү эдийн засгийн их сургуулийн оюутан Б.Хулан  
b19fa1276@ufe.edu.mn

**Удирдагч багш:** СЭЗИС-ийн ахлах багш Д.Мөнхцэцэг (МА)

#### ХУРААНГУЙ

Монгол Улсын хувьд ашигт малтмалын түүхий эд, ялангуяа зэсийн экспортоос ихээхэн хамааралтай эдийн засагтай орон боловч экспортын голлох бүтээгдэхүүн, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар хангалттай сайн судлаагүй байгаа нь учир дутагдалтай билээ.

Гэвч дэлхий даяар энэ сэдэв нь өргөнөөр судлагддаг бөгөөд сэдвийг тойрсон маргаанууд их байдаг. Ашигт малтмалын эдийн засгийн хувьд зах зээлийн суурь хүчин зүйлс болох биет эрэлт, нийлүүлэлтээр түүхий эдийн үнийн хэлбэлзлийг, ялангуяа дунд болон урт хугацаанд тайлбарладаг гэдэгтэй нэлээд санал нэгддэг. Гэсэн хэдий ч саяхны үнийн эрчимтэй өсөлтийн дараа үндсэн улс орнууд болон бүс нутгуудад хөрвөх чадвар, мөнгөний нийлүүлэлт, түүхий эдийн санхүүгийн байдал, ялангуяа санхүүгийн спекуляц арилжаа зэрэг үндсэн бус хүчин зүйлс гүйцэтгэх үүргийн талаар зарим нэг санал зөрөлдөөн бий болжээ. Энэхүү судалгаагаар нь 19 хувьсагчтай вектор авторегресс VAR-X эмпирик загварыг боловсруулан дэлхийн зэсийн зах зээл дэх бодит үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийг шинжиллээ.

Хувьсагчдын нөлөөлөл цаг хугацааны явцад өөрчлөгддөг,

үнийн динамикийг бүтцийн өөрчлөлттэй гэж тогтоосон тул судалж буй 26 жилийг дөрвөн үе (1997–2003, 2003–2008, 2008–2016, 2016–2023) гэж хуваан БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, санхүүгийн хямрал, АНУ-ын худалдааны хоригтой холбоотой гурван хугарлын цэгийг тодорхойлсон болно.

Шинжилгээнд хамрагдсан бүх хугацаанд эрэлт, нийлүүлэлт зэрэг үндсэн үзүүлэлтүүд хамааралтай хэдий ч зэсийн үнийн түвшин, түүний хэлбэлзлийг ойлгохын тулд санхүүгийн хүчин зүйлс, хөрвөх чадвар болон бусад макро эдийн засгийн хувьсагчид зайлшгүй шаардлагатай байгааг судалгааны үр дүн харуулж байна. Санхүүгийн зах зээлийн хүчин зүйлс 1997–2003 оны зэсийн үнийн өөрчлөлтийг тайлбарлахад нөлөө бүхий үзүүлэлтүүд байв. Харин макро эдийн засгийн хүчин зүйлс, зэсийн үнэ хоорондын хамаарал 2003 оноос статистик ач холбогдолтойгоор зэсийн үнийн динамикийг тайлбарлаж байна.

Иймд зэсийн үнийн динамикийг тайлбарлахад зөвхөн эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлс хангалтгүй гэдэг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.


#### УДИРТГАЛ

Манай улсын хувьд экспортын гадаад худалдаа өнгөрсөн 10 жилийн хугацаанд 92.0 хувиар өсөж, 2021 оны жилийн эцсийн байдлаар 9,247.1 сая ам.долларт буюу ДНБ-ий 20.7 хувьд хүрсэн байдаг (ҮСХ, 2023). Үүний 92 орчим хувийг нэмүү өртөг шингээгүй, эрдэс, бүтээгдэхүүн бүрдүүлдэг бөгөөд зэсийн баяжмал болон чулуун нүүрс дангаар экспортын тал орчим хувийг бүрдүүлж байна. Энэ оны буюу 2023 оны 03 сар гэхэд л уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний 88.8% хувийг зэсийн баяжмал эзэлж байна (ҮСХ, 2023). Аж үйлдвэржсэн гол орнуудтай харьцуулахад хөгжиж буй манайх шиг орнууд эдийн засгийн хувьд жижиг бөгөөд зэс гэх мэт түүхий эдийг экспортлох чиглэлээр илүү төрөлжсөн байна. Ингэснээр манай улс жижиг, нээлттэй эдийн засгийн бүтэцтэй болдог ба зөвхөн импортын барааны хувьд ч гэлтгүй

экспортын барааны хувьд мөн үнийг хүлээн авдаг (Frankel, 2010). Өөрөөр хэлбэл, бидний арилжаалж буй барааны үнэ дэлхийн зах зээл дээр ямар байна, тэр үнээр арилжаалагдана гэсэн үг юм.

Монгол Улсын эдийн засаг экспортын голлох бүтээгдэхүүн болох зэсийн үнээс ихээхэн хамааралтай гэдэг нь удаах графикаас харагдах бөгөөд зэсийн дэлхийн зах зээл дээрх үнэ болон ДНБ-ий өсөлт хоорондын шууд хамаарал сүүлийн жилүүдэд илүү их ажиглагдах болжээ. Энэ мэтчилэн түүхий эд, ялангуяа зэс нь манай улсын эдийн засгийн сайн сайхан байдалтай ихээхэн хамааралтай тул зэсийн үнэ, түүнд нөлөөлөгч хүчин зүйлийг судлах нь эдийн засгийн тогтвортой байдал, өсөлт, хөгжлийг хангахад ашиглаж болох үнэ цэнтэй мэдлэг, ойлголт болох юм.

Зураг. Зэсийн нэрлэсэн үнэ, ДНБ өсөлт



Зэс нь үйлдвэрлэлийн гол орц, шинэ эгэл аж амьдралыг цогцлоогч гэдгээрээ олон зуун жилийн турш дэлхийн өнцөг бүрд судалгааны чухал ач холбогдолтой сэдэв байсаар ирсэн юм. Тиймээс зэсийн үнийг маш олон хүчин зүйлсээр тайлбарладаг бөгөөд тогтсон нэг загвар байхгүй. Уг түүхий эдийн үнийн динамикт зах зээлийн суурь хүчин зүйлүүд болох биет эрэлт, нийлүүлэлт дунд болон урт хугацаанд гол үзүүлэлтүүд болдог гэдэг дээр ихэнх судлаачид санал нэгддэг (Koitsiwe & Adachi, 2018). Гэсэн хэдий ч үнийн богино хугацааны хэлбэлзэл, ялангуяа сүүлийн үед түүхий эдийн зах зээл дээр гарч буй өсөлт, түүнийг дагасан үнийн огцом уналт зэргийг тайлбарлахад үндсэн бус хүчин зүйлүүдийн гүйцэтгэх нөлөө их байна гэх болжээ. Зэсийн зах зээл дээрх томоохон тоглогч Чили улсын ашигт малтмалын эдийн засагчид Гузман болон Силва дэлхийн томоохон улс, бүс нутгууд дах хөрвөх чадвар буюу мөнгөний нийлүүлэлт, түүхий эдийн санхүүгийн

зах зээл дээрх спекулятив арилжаа зэрэг нь зэсийн үнийн хөдөлгөөнийг тайлбарлахад чухал ач холбогдолтой гэж үзжээ (Guzmán & Silva, 2018). Мөн тэд бусад судлаачид эдгээр үзүүлэлтийг үнийн загварчлалд үл харгалзаж байгаад шүүмжлэлтэй хандсан байна. Эдгээр хүчин зүйлсээс гадна сүүлийн үеийн судалгааны ажлуудад эдийн засаг, улс төрийн тодорхойгүй байдлын бодит эдийн засаг, санхүүгийн зах зээлд хэрхэн нөлөөлж байгааг онцлон судалж, түүхий эдийн загварчлалд чухал бүрэлдэхүүн хэмээн үзэх боллоо (Baker, Bloom, & Davis, 2012). Манай улс төлбөрийн тэнцлийн алдагдлыг экспортын орлогоороо нөхөж, эрдэс бүтээгдэхүүний экспортоос ихээхэн орлого олдог, үнэ хүлээн авагч, жижиг нээлттэй эдийн засаг боловч зэсийн үнэ, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар шинэ мэдлэг, ойлголтод тулгуурласан дорвитой судалгаа хийгээгүй байна. Иймд дээрх судалгааны асуудалд тулгуурлан дараах асуултуудыг дэвшүүлж байна.



**Асуулт 1:** Зэсийн үнийн динамикийг тайлбарлагч чухал хүчин зүйлүүд юу вэ?

**Асуулт 2:** Эдгээр нь зэсийн үнэтэй ямар хамааралтай байдаг вэ?

**Асуулт 3:** Зэсийн үнийн мөчлөгүүдэд үнийг тайлбарлагч гол хүчин зүйлүүдийн нөлөө өөрчлөгдөх үү?

## ТААМАГЛАЛ БОЛОН СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Судлагдсан байдлын тоймд үндэслэн дэвшүүлсэн асуултууддаа урьдчилан хариулж, дараах таамаглалуудыг дэвшүүлж байна.

**Таамаглал 1:** *Зэсийн үнийн динамикийг тайлбарлахад уламжлалт үзүүлэлтүүдээс гадна санхүүгийн зах зээл, хөрвөх чадвар, тодорхой бус байдлын үзүүлэлтүүд чухал ач холбогдолтой байна.*

Хөрвөх чадвар нэмэгдэх нь ерөнхийдөө ашигт малтмалын эрэлтэд эергээр нөлөөлж, түүхий эдийн үнэд ч эергээр нөлөөлөх магадлалтай. Хөрвөх чадвар нь зах зээлийн хүүтэй урвуу хамааралтай байдаг тул хүү өсөхөд, түүхий эдийн үнэ буурна гэж үздэг. Франкел 1994 онд энэ хамаарлыг судлах загварыг боловсруулсан байдаг (Frankel, 2014). Хөрвөх чадвар нь түүхий эдийн үнэд нөлөөлсөн гэсэн таамаглалыг дэмжихийн тулд түүхий эдийн үнийн хамтарсан хөдөлгөөнийг Пиндик болон Ротемберг 1990 онд, эрсдэлийн урамшууллын бууралт болон хүү хоорондын сөрөг түүхэн хамаарлыг Франкел 2014 онд тус тус эмпирикээр баталсан байна (Pindyck & Rotemberg, 1988). Зэсийн үнэд санхүүгийн зах зээлийн гүйцэтгэсэн үүргийн тухайд хамгийн нөлөө бүхий судалгаа 2013 оны Шао нарын ажил байв (Shao, Dong, Parkinson, & Li, 2013). Энэхүү нийтлэлд үнийн хөөргөдлийг бий болгоход санхүүгийн спекуляцын гүйцэтгэдэг үүргийг ARCH болон GARCH төрлийн эконометрик загваруудыг ашиглан судалсан ба түүхий эдэд хөрөнгө оруулах нь зэсийн үнийн хэлбэлзлийн гол шалтгаан биш ч, үнийн хэлбэлзлийг бууруулах хандлагатай байгааг тогтоожээ. Гуравдугаарт, сүүлийн үед статистик арга аргачлал хөгжиж байгаатай холбогдон тодорхойгүй байдлыг хэмжих үзүүлэлтүүд хугацаан цуваан хэлбэрээр бий болсны хамгийн түгээмэл ашиглагддаг Бейкер, Блүүм нарын EPU буюу эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдлын индекс юм. Энэхүү сонинд суурилсан тодорхойгүй байдлын индексийг түүхий эдийн зах зээлийн тодорхой тохиолдлын хувьд өгөөж, хэлбэлзлийг урьдчилан таамаглах чадварыг хэд хэдэн судалгаанд авч үзсэн байна (Moore, 2017; Jolts, Mignon, & Razafindrabe, 2017; Henzel & Rengel, 2017).

**Таамаглал 2:** *Зэсийн үнийн мөчлөгүүдэд үнийн динамикийг тайлбарлагч гол хүчин зүйлсийн нөлөө өөрчлөгдөнө.*

Хуан Игнасио Гузман, Энрике Силва нарын хийсэн судалгаа нь зэсийн үнийг тодорхойлоход голлон анхаарч, ялангуяа суурь хүчин зүйлүүд болон суурь бус хүчин зүйлсийн үүргийг үнийн өөр өөр мөчлөгд харьцуулсан байна. Судалгааны үр дүнд Хятадын эрэлт

зэсийн зах зээлд үнийн мөчлөг бүрд ихээхэн ач холбогдолтой байжээ. Харин суурь бус хүчин зүйлсийн хувьд үнийн зарим мөчлөгт нөлөө нь ялгаатай байхын зэрэгцээ ач холбогдолгүй байх ч тохиолдол илэрсэн байна (Guzmán & Silva, 2018).

### Зэсийн үнэд нөлөөлөгч хүчин зүйлүүдийн талаар хийгдсэн судалгаа

Хуан Игнасио Гузман, Энрике Силва нарын хийсэн судалгаа нь зэсийн үнийг тодорхойлоход голлон анхаарч, ялангуяа суурь хүчин зүйлүүд болон суурь бус хүчин зүйлсийн үүргийг харьцуулсан байна. Судалгаанд дурдсан асуудал нь эрэлт нийлүүлэлтийн динамик, макро эдийн засгийн үзүүлэлт зэрэг суурь хүчин зүйлсийн харьцангуй ач холбогдлыг хөрөнгө оруулагчдын сэтгэл хөдлөл, таамаглалын зан төлөв зэрэг үндсэн бус хүчин зүйлүүдтэй харьцуулан судлах явдал байв. Тэд зэсийн үйлдвэрлэлийн түвшин, хэрэглээ, макро эдийн засгийн үзүүлэлтүүд, хөрөнгө оруулагчдын сэтгэл хөдлөлийн индекс, санхүүгийн зах зээлийн хувьсагчдыг багтаасан үндсэн болон суурь бус хүчин зүйлсийг багтаасан хувьсагчдыг сонгосон. Шинжилгээний сонгосон арга нь эконометрик загварчлал, регрессийн шинжилгээ, магадгүй хугацааны цувралын шинжилгээ эсвэл самбар өгөгдлийн шинжилгээ зэрэг аргуудыг ашигласан. Судалгааны гол үр дүн нь зэсийн үнийг тодорхойлоход суурь болон суурь бус хүчин зүйлсийн харьцангуй хувь нэмрийн талаарх ойлголтыг өгч, зах зээлийн суурь динамикийг тодруулж, үнийн хэлбэлзлийн талаарх бидний ойлголтыг нэмэгдүүлсэн (Guzmán & Silva, 2018).

Жосефын хийсэн судалгаагаар түүхий эдийн регрессийн загвараар дэлхийн хувьсагчдын зэсийн үнийг тайлбарлах чадварыг шинжилжээ. Үр дүнд нь дэлхийн ДНБ болон аграгет нэрлэсэн долларыг багтаасан энгийн загвар нь үнийн хөдөлгөөнийг тайлбарлахад чухал хувьсагчид болохыг тогтоосон байна (Gruber, 2011).

Жуан, Габриал нар түүхий эдийг таамаглах чадвартай хувьсагчдыг зэсийн үнийн хувьд загварчилжээ. Эдийн засгийн хэд хэдэн хувьсагч нь зэсийн хэлбэлзлийг урьдчилан таамаглахад үнэтэй мэдээлэл өгдөг болохыг тэд тогтоожээ. Зэсийн илүүдэл эрэлтийн хэмжүүр, өгөөж, тодорхойгүй байдлын ихэнх хүчин зүйлс, S&P 500 индексийн өгөөж, алт, газрын тос, түүхий эдийн валют зэрэг санхүүгийн хувьсагчууд нь ирээдүйн зэсийн хэмжээг урьдчилан таамаглахад чухал үүрэгтэй байжээ (Dhaz, Hansen, & Cabre-ra, 2021). Дараах хүснэгтэд зэсийн үнийг судлахад авч үзсэн хувьсагчдыг хүснэгтлэн харууллаа

*Хөрвөх чадвар гэдэг нь хөрөнгө, үнэт цаасыг зах зээлийн үнэд нөлөөлөхгүйгээр бэлэн мөнгө болгон хөрвүүлэхэд хялбар байдлыг хэлнэ.*

## Хүснэгт. Судлагдсан хувьсагч

НЭР	ХУВЬСАГЧИД	АРГА ЗҮЙ	ЭХ СУРВАЛЖ
COPPER PRICE DETERMINATION: FUNDAMENTALS VERSUS NONFUNDAMENTALS	<ul style="list-style-type: none"> <li>◆ Хамааран хувьсагч:</li> <li>◆ Зэсийн спот захын үнэ</li> <li>◆ Зэсийн фьючерс захын үнэ (3 сарын гэрээ)</li> <li>◆ Биржийн эзэмшиж буй нийт зэсийн агуулахын нөөц</li> <li>◆ Авах захиалга</li> <li>◆ Илүүдэл спекуляцын индекс</li> <li>◆ Үл хамаарах хувьсагч:</li> <li>◆ Дэлхийн аж үйлдвэржилтийн индекс</li> <li>◆ Балтик Драй индекс(BDI)</li> <li>◆ Долларын индекс</li> <li>◆ S&amp;P500 индекс</li> <li>◆ Бодит биржийн газрын тосны үнэ</li> <li>◆ Голдман Сакс түүхий эдийн индекс</li> <li>◆ Лондоны банк хоорондын хүү</li> <li>◆ Хятадын мөнгөний нийлүүлэлт</li> <li>◆ Европын мөнгөний нийлүүлэлт</li> <li>◆ АНУ-ын мөнгөний нийлүүлэлт</li> </ul>	VAR-X (Vector Autoregressive with Exogenous)	(Guzmán & Silva, 2017)
MODELING COMMODITY PRICE	<ul style="list-style-type: none"> <li>◆ Хамааран хувьсагч:</li> <li>◆ Түүхий эдийн үнэ</li> <li>◆ Үл хамаарах хувьсагч:</li> <li>◆ Дэлхийн ДНБ</li> <li>◆ Дэлхийн аж үйлдвэржилт</li> <li>◆ Дэлхийн үйлдвэрлэлийн зөрүү</li> <li>◆ Дэлхийн инфляц</li> <li>◆ ОПЕК үйлдвэрлэл</li> <li>◆ Санхүүгийн стресс</li> <li>◆ Санхүүгийн зах зээл дээрх захиалга</li> <li>◆ Үйлдвэрлэлийн индекс</li> </ul>	OLS (Ordinary Least Squares)	(Gruber, 2011)
ECONOMIC DRIVERS OF COMMODITY VOLATILITY: THE CASE OF COPPER	<ul style="list-style-type: none"> <li>◆ Хамааран хувьсагч:</li> <li>◆ Зэсийн үнийн хэлбэлзэл</li> <li>◆ Үл хамаарах хувьсагч:</li> <li>◆ Илүүдэл эрэлт</li> <li>◆ Зэсийн агуулахын нөөц</li> <li>◆ Хадгалалтын өгөөж</li> <li>◆ Балтик Драй индекс</li> <li>◆ VIX индекс</li> <li>◆ EPU индекс</li> <li>◆ Мөнгөний тодорхойгүй байдлын индекс</li> <li>◆ Геополитикийн индекс (түүхэн)</li> <li>◆ Геополитикийн индекс (тогтоол)</li> <li>◆ Геополитикийн индекс (аюул)</li> <li>◆ Эрсдэлээс зайлсхийх индекс</li> <li>◆ S&amp;P500 индекс</li> <li>◆ Алтны өгөөж</li> <li>◆ Газрын тосны өгөөж</li> <li>◆ Чилийн доллартой харьцах ханш • Австралийн доллартой харьцах ханш</li> <li>◆ Рио Тинто хувьцааны өгөөж • Фрийпорт Мкморан хувьцааны өгөөж</li> <li>◆ BHP Биллитон хувьцааны өгөөж</li> <li>◆ Алкое хувьцааны өгөөж</li> </ul>	BMA (Bayesian Model Averaging)	(Dhaz, Hansen, & Cabrera, 2021)

## ОНОЛЫН УХАГДАХУУН БА ЗАГВАР

Энэхүү хэсэгт зэсийн талаарх ерөнхий ойлголт болон түүний үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийн гол хамаарлын талаар баримт болон онолын ойлголтыг харуулахыг зорилоо. Түүхий эд, ялангуяа зэс гэх мэт хадгалагдах боломжтой бүтээгдэхүүний

хувьд үнэ нь үүсмэл санхүүгийн хэрэгсэл, фьючерсийн зах зээлтэй нягт уялдаатай байдаг байна. Түүний үнэ нь зөвхөн биет зах зээлийн хүчин зүйлээс гадна, бэлэн мөнгөний зах зээлийн огтлолцоор тодорхойлогддог.

### 2.3 Зэсийн үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийн хамаарал

#### Эрэлт:

Зэсийн эрэлт нэмэгдэх нь зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгож, үнэ өсөхөд нөлөөлж байгаа тул зэсийн үнэд эергээр нөлөөлнө. Зэсийг эрэлхийлж буй худалдан авагчдын тоо нэмэгдэж байгаа тул худалдагч нар илүү өндөр үнээр зарах боломж бүрддэг. Нэмж дурдахад эрэлт нэмэгдэж байгаа нь эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг улам чангалж, улмаар зэсийн хомсдол үүсгэж, үнэ өсөхөд хүргэж болзошгүй юм. Эрэлт нэмэгдсэнээс үүссэн зах зээлийн эерэг хандлага нь эдийн засгийн идэвхжил, аж үйлдвэрийн өргөжилтийг илэрхийлдэг тул үнэ өсөхөд нөлөөлж байна. Түүгээр ч зогсохгүй зэсэд тулгуурладаг төрөл бүрийн салбарын эрэлт нэмэгдэж байгаа нь үнийн өсөлтийн дарамтыг улам бүр тогтвортой байлгаж байна. Түүхий эдийн эрэлт, ялангуяа хурдацтай хөгжиж буй зах зээлийн эдийн засагтай орнуудын эрэлт нь сүүлийн 10 хэдэн жилийн түүхий эдийн үнийн өсөлтийн хамгийн их эш татсан тайлбар байж магадгүй юм. Үүний нэгэн адил 2008 оны сүүлээр түүхий эдийн үнийн уналт, сүүлийн хоёр жилийн үнийн өсөлттэй зэрэгцэн түүхий эдийн эрэлт огцом буурч, улмаар сэргэлт ажиглагдсан байна.

#### Валютын ханш:

Валютын ханш нь үйлдвэрлэлийн зардал, экспортын өрсөлдөх чадвар, дэлхийн зах зээлийн динамик зэрэгт нөлөөлж, зэсийн эрэлт нийлүүлэлтийн динамик байдалд нөлөөлдөг тул зэсийн үнийг тайлбарлахад чухал ач холбогдолтой. Чили дэлхийн хамгийн том зэс үйлдвэрлэгчийн хувьд чухал үүрэгтэй тул Чилийн ханшийн өсөлт нь зэсийн үнэд сөргөөр нөлөөлнө. Чилийн песо илүү хүчтэй байх нь уул уурхайн компаниудын үйлдвэрлэлийн зардлыг өсгөж, ашигт ажиллагааг хадгалах зорилготой тул нийлүүлэлтийг бууруулахад хүргэж болзошгүй юм. Нэмж дурдахад валютын ханшийн өсөлт нь Чилийн зэсийн экспортыг гадаад зах зээлд харьцангуй үнэтэй болгож, тэдний өрсөлдөх чадварыг бууруулж, эрэлтийг бууруулах магадлалтай. Түүнчлэн валютын ханшийн хэлбэлзэл нь бусад орны зэстэй харьцуулахад Чилийн зэсийн үнэд нөлөөлж, дэлхийн зах зээлийн динамик байдалд нөлөөлж, зэсийн

үнэ буурах дарамт үүсгэж болзошгүй юм. Тиймээс Чилийн ханшийн өсөлт нь зэсийн үнэд сөргөөр нөлөөлнө.

#### Хуурай тээвэрлэлт:

Балтик Драй индекс (BDI) зэрэг үзүүлэлтээр илэрхийлэгддэг хуурай тээвэрлэлт нь дэлхийн эдийн засгийн идэвхжил, худалдааны хэмжээ, зэсийн эрэлт, нийлүүлэлтийн динамик байдалд нөлөөлж болох логистикийн хүчин зүйлсийг тусгадаг тул зэсийн үнийг тайлбарлахад чухал ач холбогдолтой. Балтын хуурай индекс (BDI) өссөн нь зэсийн үнэд эергээр нөлөөлдөг. BDI нь хуурай задгай түүхий эд, тэр дундаа зэсийн тээвэрлэлтийн зардлын дэлхийн хэмжээнд өргөн ашиглагддаг үзүүлэлт юм. BDI өсөхөд тээврийн үйлчилгээний эрэлт нэмэгдэж, эдийн засгийн идэвхжил, олон улсын худалдаа нэмэгдэж байгааг харуулж байна. Эдийн засгийн идэвхжилийн энэхүү өсөлт нь ихэвчлэн барилга, үйлдвэрлэл зэрэг төрөл бүрийн салбарт хэрэглэгддэг зэс зэрэг түүхий эдийн эрэлтийг нэмэгдүүлдэг. BDI өсөхийн хэрээр түүхий эдийн эрэлт нэмэгдэж байгааг илтгэж, нийлүүлэлтийн сүлжээний боломжит хязгаарлалтыг харуулж байгаа бөгөөд энэ нь тээвэрлэлтийн зардлыг нэмэгдүүлж, зэсийн үнэд шууд бусаар нөлөөлж болзошгүй юм. Түүгээр ч зогсохгүй BDI өндөр байгаа нь зах зээлийн эерэг хандлагыг бий болгож, хөрөнгө оруулагчдыг зэс рүү татах, улмаар үнийг өсгөхөд хүргэдэг. Тиймээс Балтын хуурай индексийн өсөлт нь ерөнхийдөө зэсийн үнэд эергээр нөлөөлж байна.

#### Эрсдэлээс зайлсхийх байдал:

Эрсдэлээс зайлсхийх нь ихэвчлэн зэсийн үнэд сөргөөр нөлөөлдөг. Эрсдэлээс зайлсхийх гэдэг нь тодорхойгүй байдал эсвэл зах зээлийн тогтворгүй байдлын үед хөрөнгө оруулагчид илүү болгоомжтой байж, илүү найдвартай хөрөнгө хайж байдаг мэдрэмжийг хэлдэг. Ийм нөхцөлд хөрөнгө оруулагчид эрсдэлд илүү мэдрэмтгий гэж тооцогддог зэс зэрэг түүхий эдэд өртөх эрсдэлээ бууруулах хандлагатай байдаг. Ийнхүү эрэлт буурснаар зэсийн үнэ буурах боломжтой. Нэмж дурдахад эрсдэлээс зайлсхийх нь ихэвчлэн

эдийн засгийн уналт эсвэл санхүүгийн хямралыг дагалддаг бөгөөд энэ нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бууруулж, барилга, үйлдвэрлэл зэрэг янз бүрийн салбарт ашигладаг зэсийн эрэлтийг бууруулдаг. Улмаар эрсдэлгүй үед хөрөнгө оруулагчдын эрэлт буурч, үйлдвэрлэлийн эрэлт суларсан зэрэг нь зэсийн үнэд ерөнхийдөө буурах дарамт болж байна.

### Эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдал:

Эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдал нэмэгдэх нь ихэвчлэн зэсийн үнэд сөргөөр нөлөөлдөг. Эдийн засгийн бодлогыг тойрсон тодорхойгүй байдлын түвшин өндөр байвал хөрөнгө оруулагчдын дунд эргэлзээ, эрсдэлээс зайлсхийх орчныг бий болгож чадна. Засгийн газрын зохицуулалт, худалдааны бодлого, геополитикийн хурцадмал байдлын талаарх тодорхойгүй байдал нь хөрөнгө оруулагчдын итгэлийг бууруулж, эдийн засгийн нийт идэвхжил буурахад хүргэдэг. Үүнийг дагаад аж үйлдвэрийн салбараас ихээхэн хамааралтай зэсийн эрэлт буурч магадгүй байна. Эрэлт ийнхүү буурснаар зэсийн үнэ буурах дохио болно. Цаашилбал, эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдал нь нийлүүлэлтийн сүлжээг тасалдуулж, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад саад болж, үйлдвэрлэл буурч, цаашид зэсийн үнэд сөргөөр нөлөөлнө. Иймд эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдал нэмэгдэх нь ерөнхийдөө зэсийн үнэд сөргөөр нөлөөлж байна.

### Геополитикийн эрсдэл:

Геополитикийн эрсдэл нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалж зэсийн үнэд эерэг болон сөрөг нөлөө үзүүлдэг. Ерөнхийдөө геополитикийн хурцадмал байдал эсвэл зөрчилдөөн нь зах зээлийн тодорхойгүй байдлыг бий болгож, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээг тасалдуулж, зэсийн үнийг өсгөх эрсдэлтэй. Худалдааны маргаан, хориг арга хэмжээ, улс төрийн тогтворгүй байдал, бүс нутгийн мөргөлдөөн зэрэг хүчин зүйлүүд нь нийлүүлэлтийн тасалдал, үйлдвэрлэл буурах, эсвэл зэс үйлдвэрлэдэг бүс нутгуудад нэвтрэх боломжийг хязгаарлахад хүргэдэг. Эдгээр тасалдал нь зэсийн нийлүүлэлтийг чангаруулж, үнэ өсөхөд хүргэдэг. Нөгөөтээгүүр, геополитикийн эрсдэлүүд нь дэлхийн эдийн засгийн өсөлт, аж үйлдвэрийн идэвхийг бууруулж, зэсийн эрэлтийг бууруулж, үнэ буурах дарамтыг бий болгож болзошгүй юм. Геополитикийн эрсдэлийн зэсийн үнэд үзүүлэх цэвэр нөлөө нь геополитикийн үйл явдлуудаас үүдэлтэй нийлүүлэлтийн тасалдал болон эрэлтийн динамикийн өөрчлөлтийн тэнцвэрт байдлаас хамаарна.

### S&P 500 (SP500) индекс:

S&P 500 индекс (SP500) нь хөрөнгө оруулагчдын сэтгэл зүй, эдийн засгийн төлөв байдал, үйлдвэрлэлийн эрэлтэд нөлөөлж байгаа учраас зэсийн үнийг тайлбарлахад чухал ач холбогдолтой. SP500 нь янз бүрийн салбар дахь АНУ-ын томоохон компаниудын гүйцэтгэлийг илэрхийлдэг, өргөн дагаж мөрддөг хөрөнгийн зах зээлийн индекс юм. Энэ нь зах зээлийн мэдрэмж, эдийн засгийн ерөнхий эрүүл мэндийн барометр болдог. SP500 сайн ажиллаж байгаа үед энэ нь хөрөнгө оруулагчдын эерэг хандлага, эдийн засгийн өсөлтийг өөдрөгөөр төсөөлж байгааг илтгэдэг. Барилга, үйлдвэрлэл, дэд бүтцийн төслүүдэд ашигладаг үйлдвэрлэлийн гол металл болох зэсийн энэхүү эерэг хандлага нь зэсийн эрэлтийг нэмэгдүүлж чадна. Нэмж дурдахад SP500-ийн гүйцэтгэл нь эрсдэлийн дур сонирхол, хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлж, зах зээлийн динамик болон зэс зэрэг түүхий эдийн эрэлтэд нөлөөлдөг. Тиймээс SP500 болон зэсийн үнийн хоорондын хамаарлыг шинжлэх нь эдийн засгийн өргөн хүрээний нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын сэтгэл хөдлөлийн талаарх ойлголтыг өгөхөд тусалдаг бөгөөд энэ нь зэсийн үнийн хөдөлгөөнийг тайлбарлахдаа анхаарах чухал хүчин зүйл болдог.

### Санхүүгийн зах зээлийн идэвхжил:

WTI (West Texas Intermediate) газрын тосны үнэ, GSCI (Goldman Sachs Commodity Index), VIX (Volatility Index) зэрэг нь санхүүгийн нөлөөгөөр зэсийн үнэд эергээр нөлөөлөх боломжтой. Санхүүжилт гэдэг нь түүхий эдийн зах зээл дэх санхүүгийн зах зээлд оролцогчдын оролцоо нэмэгдсэнийг хэлдэг бөгөөд энэ нь үнийн хэлбэлзэл, харилцан хамаарал нэмэгдэхэд хүргэдэг. Санхүүгийн зах зээлийн эерэг хандлага WTI нефтийн үнийн өсөлт, GSCI-ийн өсөлт зэрэгт тусгагдсан үед энэ нь таамаглалын сонирхол, хөрөнгө оруулалтын урсгалыг түүхий эд, тэр дундаа зэс рүү татах боломжтой. Энэ нь санхүүгийн идэвхжил нэмэгдсэнээр зэсийн үнийг өсгөх боломжтой. Нэмж дурдахад "айдсын индекс" гэж нэрлэгддэг VIX нь зах зээлийн тогтворгүй байдал, эрсдэлээс зайлсхийх байдлыг хэмждэг. VIX бага байх үед хэлбэлзэл багатай, хөрөнгө оруулагчдын түгшүүр багасаж байгаа нь эрсдэлд орох, хөрөнгө оруулагчдын зэс зэрэг түүхий эдийг сонирхох хүсэл эрмэлзлийг бий болгож, үнэ өсөхөд хүргэдэг. Тиймээс санхүүгийн зах зээлд оролцогчид эрэлтийг нэмэгдүүлж, зах зээлийн динамик байдалд нөлөөлж байгаа тул WTI, GSCI, VIX-ийн үзүүлсэн санхүүгийн нөлөөлөл нь зэсийн үнэд эергээр нөлөөлнө.

### Хүүгийн түвшин ба хөрвөх чадвар:

Онолын хувьд бага хүүтэй байх нь бараа материал хадгалах зардлыг бууруулж, улмаар эрэлтийг нэмэгдүүлэх замаар үнийг өсгөж чадна. Нэмж дурдахад бага хүү нь хөрөнгө оруулагчдыг өгөөжийг эрэлхийлж, түүхий эд рүү хөтөлж, улмаар үнийг өсгөдөг гэж ихэвчлэн баталдаг. LIBOR (London Interbank Offered Rate) нь зээл, дериватив, бонд зэрэг янз бүрийн санхүүгийн гэрээнд ашиглагддаг хүүгийн жишиг үзүүлэлт юм. LIBOR өөрөө зэсийн үнэд шууд нөлөөлдөггүй ч LIBOR хүүгийн өөрчлөлт нь зах зээлийн хөрвөх чадвар, санхүүжилтийн зардал, хөрөнгө оруулагчдын сэтгэл зүйд үзүүлэх нөлөөгөөр зэсийн үнэд шууд бусаар нөлөөлдөг. Жишээлбэл, хэрэв LIBOR-ын хувь хэмжээ өсвөл бизнес эрхлэгчдийн зээлийн зардал нэмэгдэж, үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, барилга, үйлдвэрлэл гэх мэт зэс их шаарддаг үйл ажиллагаанд хөрөнгө оруулах чадварт нөлөөлж болзошгүй. Энэ нь зэсийн эрэлтийг бууруулж, үнэ буурахад хүргэж болзошгүй юм. Түүнчлэн, LIBOR-ын хүүгийн өөрчлөлт нь зах зээлийн ерөнхий нөхцөл байдалд өөрчлөлт оруулах дохио болж, хөрөнгө оруулагчдын мэдрэмж, эрсдэлийн дуршилд нөлөөлж болзошгүй юм. Хэрэв LIBOR-ын хүү өндөр байгаа нь эдийн засгийн тодорхойгүй байдал эсвэл зээлийн нөхцөл чангарч байгаагийн шинж тэмдэг гэж үзвэл эрсдэлээс зайлсхийх, зэсийн эрэлт буурахад хүргэж болзошгүй юм. Иймд LIBOR өөрөө зэсийн үнийг шууд тодорхойлдоггүй ч зах зээлийн нөхцөл байдал, санхүүжилтийн зардал, хөрөнгө оруулагчдын хандлага зэрэг нь зэсийн үнийн хөдөлгөөнд шууд бусаар нөлөөлдөг. Харвардын их сургуулийн эдийн засагч, профессор Жеффри Франкел LIBOR болон зэсийн үнийн хоорондын хамаарлын талаар өөр ойлголттой байж магадгүй юм. Өндөр хүү нь хадгалагдах түүхий эдийн үнийг дөрвөн сувгаар бууруулдаг (Frankel, 2014). Үүнд:

- Маргааш гэхээсээ өнөөдөр олборлох урамшууллыг нэмэгдүүлэх зам (Hotelling, 1980)
- Пүүсүүдийн түүхий эд хадгалах хүслийг бууруулах зах
- Спекуляцид түүхий эдийн гэрээнээсээ татгалзаж, төрийн сангийн үнэт цаас руу шилжүүлэхийг дэмжих зам
- Дотоодын мөнгөн тэмдэгтийн ханшийг өсгөж, улмаар олон улсад худалдаалагдаж буй түүхий эдийн үнийг гадаад валютын ханшаар бууруулаагүй байсан ч дотоодын зах зээл дээрх үнийг бууруулах зам

Бүх дөрвөн механизм нь 1980–аад оны эхээр бодит хүү өндөр байсан үеийн зах зээлийн бодит үнийг бууруулахын тулд ажилладаг. Бодит зээлийн хүү буурах нь эсрэгээрээ бараа материалын тээвэрлэлтийн зардлыг бууруулж, түүхий эдийн үнийг өсгөнө.

### Түүхий эдийн зах зээлийг санхүүжүүлэх:

Эдгээр зах зээлд санхүүгийн хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэж байгаа нь түүхий эдийн үнэ өсөх хандлагатай байна гэж нийтлэг маргаж байна. Хөрөнгө оруулагчдын урсгалын нийтлэг төлөөлөгч нь фьючерсийн зах зээлийн нээлттэй сонирхол болон арилжааны бус арилжаачдын цэвэр урт позиц буюу авах гэрээ юм.

### Хөрвөх чадвар ба мөнгөний нийлүүлэлт:

Мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлт зэсийн үнэд үзүүлэх нөлөөллийг хөрвөх чадварын нөлөө гэж ойлгож болно. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь эдийн засагт хөрвөх чадварыг бий болгодог бөгөөд энэ нь зэсийн үнэд эергээр нөлөөлнө. Нэмэлт хөрвөх чадвар нь худалдан авах чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн идэвхжил, тэр дундаа зэсийн эрэлтийг идэвхжүүлнэ. Улмаар зах зээлд хөрвөх чадвар нэмэгдсэнтэй холбоотойгоор зэсийн үнэ өсөх магадлалтай. Нөгөөтээгүүр, мөнгөний нийлүүлэлт буурах эсвэл зээлийн нөхцөл чангарах нь хөрвөх чадварыг бууруулж, эдийн засгийн идэвхжил, эрэлт сулрах үед зэсийн үнэ буурах магадлалтай. Иймээс мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлтийн хөрвөх чадварт үзүүлэх нөлөөг ойлгох нь мөнгөний нөхцөл ба зэсийн үнийн хөдөлгөөний хоорондын хамаарлыг шинжлэхэд тусална. Европ, АНУ, Хятад дахь мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлт нь зэсийн үнэд ихээхэн нөлөөлнө. Мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тэлэх мөнгөний бодлого нь эдийн засгийн өсөлтийг өдөөж, барилга, үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарт зэсийн эрэлтийг нэмэгдүүлэхэд хүргэдэг. Ийнхүү эрэлт нэмэгдэж байгаа нь зэсийн үнийг өсгөхөд хүргэж болзошгүй юм. Эсрэгээр, мөнгөний хумих бодлого эсвэл зээлийн нөхцөлийг чангатгах нь эдийн засгийн идэвхжилийг бууруулж, зэсийн эрэлтийг бууруулж, зэсийн үнэ буурахад хүргэж болзошгүй юм. Эдгээр бүс нутгийн мөнгөний нийлүүлэлт нь хөрвөх чадвар, хөрөнгө оруулалт, хэрэглээний зардалд нөлөөлдөг бөгөөд энэ нь эцсийн дүндээ зэсийн эрэлтийн динамик байдалд нөлөөлдөг. Гэхдээ мөнгөний нийлүүлэлт болон зэсийн үнийн хоорондын хамааралд дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, зэсийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн динамик,

геополитикийн үйл явдлууд зэрэг янз бүрийн хүчин зүйлс нөлөөлдөг гэдгийг анхаарах нь чухал юм (Hooldbrook, 1960).

### Фьючерс:

Фьючерсийн үнэ нь түүхий эдийн зах зээлийн спот үнэд нөлөөлдөг. Фьючерс зах зээл нь үнийг илрүүлэх платформ болж, ирээдүйн спот үнийн зах зээлийн хүлээлтийг тусгадаг. Худалдаачид болон хөрөнгө оруулагчид шинэ мэдээлэл, өөрчлөгдөж буй сэтгэл хөдлөлд тулгуурлан фьючерсийн гэрээг идэвхтэй арилжаалж байгаа тул эдгээр гүйлгээ нь хөгжиж буй зах зээлийн хүлээлтийг илтгэх замаар спот үнэд нөлөөлж чадна. Нэмж дурдахад фьючерсийн зах зээл нь арбитражийн боломжийг бий болгодог бөгөөд арилжаачид фьючерс болон спот үнийн хоорондох үнийн зөрүүг ашиглаж болно. Арбитражийн үйл ажиллагаа нь зах зээлд оролцогчид ашиг олох боломжийг ашиглахын тулд үндсэн түүхий эдийг нэгэн зэрэг худалдан авах эсвэл зарах үйл ажиллагаа явуулдаг тул фьючерс болон спот үнийг тохируулахад тусалдаг. Ерөнхийдөө фьючерсийн үнэ нь мэдээллээр хангах, зах зээлийн мэдрэмжийг тусгах, арбитрын үйл ажиллагааг дэмжих замаар спот үнийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

### Илүүдэл спекуляц:

Түүхий эдийн зах зээл, тэр дундаа зэсийн илүүдэл спекуляц нь ашиг олох зорилготой арилжаа хэвийн буюу шаардлагатай гэж үзсэн хэмжээнээс давж гарахыг хэлнэ. Зэсийн үнэд илүүдэл спекуляцын нөлөө үзүүлэх нь ээдрээтэй бөгөөд маргаантай сэдэв юм. Илүүдэл спекуляц нэмэгдэх нь зэсийн үнэд эерэг болон сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Энэ нь нэг талаар зах зээлд үнийн хэлбэлзэл, гажуудлыг нэмэгдүүлж, зэсийн үнийг өсгөж, улам тогтворгүй болгоход хүргэж болзошгүй юм. Нөгөөтээгүүр, спекуляц нь хөрвөх чадварыг бий болгож, фьючерсийн зах зээл дээрх үнийн нээлтийг сайжруулж, зэсийн үнийг илүү үр ашигтай, тогтвортой байлгахад хувь нэмэр оруулдаг. Илүүдэл спекуляцын нөлөө нь зэсийн үнэд үзүүлэх цэвэр нөлөө нь зах зээлийн нөхцөл байдал, спекулячид болон хеджерүүдийн хоорондын тэнцвэрт байдал, дамын үйл ажиллагааг зохицуулах зохицуулалтын арга хэмжээний үр нөлөө зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг. Илүүдэл спекуляцыг хэмжихэд Воркингийн томьёог ашиглаж болно (Hooldbrook, 1960).

$$wt = \left( \begin{array}{l} \frac{1 + SS}{HL + HS} \quad \text{бол } HL \geq HS \\ \frac{1 + SL}{HL + HS} \quad \text{бол } HL \leq HS \end{array} \right)$$

- Энд HL ба HS нь худалдааны авах болон зарах гэрээ бөгөөд SL ба SS нь худалдааны бус авах болон зарах гэрээ болно.
- Худалдааны авах болон зарах гэрээ – Үндсэн түүхий эдийг үйлдвэрлэх, боловсруулах, хэрэглэхэд оролцдог аж ахуйн нэгжүүд эзэмшдэг. Эдгээр аж ахуйн нэгжүүд нь уг түүхий эдийг худалдааны сонирхолтой гэж үздэг бөгөөд үнийн эрсдэлийг удирдах, хамгаалахын тулд фьючерсийн гэрээг ашигладаг. Жишээлбэл, зэс үйлдвэрлэгч эсвэл үйлдвэрлэгчид зэсийн зах зээл дээр гарч болзошгүй үнийн хэлбэлзлээс хамгаалах зорилгоор гэрээ эзэмшдэг.
- Худалдааны бус авах болон зарах гэрээ – Спекуляц хийх зорилгоор шууд худалдааны сонирхолгүй аж ахуйн нэгжүүд эзэмшдэг фьючерсийн гэрээнүүд юм. Спекулячид фьючерсийн зах зээл дээрх хүлээгдэж буй үнийн өөрчлөлтөөс ашиг олохыг эрмэлздэг таамаглалын сэдэлтэй байдаг.
- Авах гэрээ – Зах зээлд оролцогч фьючерсийн гэрээ гэх мэт санхүүгийн хэрэгслийг үнэ нь буурна гэсэн хүлээлттэй зарах үед үүсдэг. Өөрөөр хэлбэл, үндсэн хөрөнгийн үнэ буурна гэж бооцоо тавьж байна гэсэн үг юм.
- Зарах гэрээ – Зах зээлд оролцогч санхүүгийн хэрэгслийн үнэ нь өснө гэсэн хүлээлттэй худалдан авахыг хэлнэ. Энэ гэрээг эзэмшигчид зах зээлийн өсөлтийг хүлээж байгаа эсвэл үнийн өсөлтөөс ашиг олохыг эрмэлздэг.

**Зэсийн фьючерс хэлцлийн авах гэрээ:**

Энэ нь зэсийн үнэд эерэгээр нөлөөлнө. Зах зээлд оролцогчид авах гэрээ эзэмшдэг бол энэ нь тэдний ирээдүйн үнийн өсөлтийн хүлээлтийг илэрхийлж байгаа юм. Зэсийн фьючерсийн эрэлт нэмэгдэж байгаа нь спот зах зээлд орж, үнэ өсөхөд хүргэж болзошгүй юм. Зэсийг авах гэрээ нь фьючерсийн зах зээл дээр үнэ тогтооход хувь нэмэр оруулж, зах зээлийн сэтгэл хөдлөлд нөлөөлдөг бөгөөд энэ нь спот үнэд хариу үйлдэл үзүүлэх боломжтой.

**Биржийн агуулахад байгаа зэсийн нөөц:**

Зэсийн биржийн нөөц нь зэсийн үнэд нөлөөлж болзошгүй. Биржийн агуулахын өсөлт нь ерөнхийдөө зэсийн нийлүүлэлт илүүдэлтэй байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь олдоц нэмэгдсэний улмаас үнэ буурах дарамт учруулж болзошгүй юм. Эсрэгээр, биржийн хувьцааны бууралт нь нийлүүлэлт буурч байгааг илтгэж, эрэлт нийлүүлэлтээс давж болзошгүй тул үнэ өсөх магадлалтай. Биржийн хувьцааны мониторинг нь зэсийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрт байдлын талаарх ойлголтыг өгч, зах зээлд оролцогчдод зах зээлийн нөхцөл байдлыг үнэлэхэд тусалдаг. Гэсэн хэдий ч биржийн агуулахын нөөц болон зэсийн үнийн хамааралд дэлхийн эдийн засгийн чиг хандлага, геополитикийн үйл явдлууд, хөрөнгө оруулагчдын хандлага зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд биржийн үнэт цаас зэсийн үнэд хэрхэн нөлөөлж буйг шинжлэхдээ үүнийг анхаарч үзэх хэрэгтэй.

**Зэсийн биржийн нөөц:**

Зэсийн биржийн нөөц нь зэсийн үнэ өсөх, буурахаас хамаарч эерэг эсвэл сөрөг нөлөө үзүүлдэг. Биржийн нөөцийн өсөлт нь зах зээлд зэсийн илүүдэл эсвэл илүүдэл нийлүүлэлтийг илтгэдэг тул зэсийн үнэ буурах хандлагатай байдаг. Энэ нь металлын олдоц нэмэгдсэний улмаас үнэ буурахад хүргэж болзошгүй юм. Эсрэгээр, биржийн хувьцааны бууралт нь нийлүүлэлт багасаж, хомсдол үүсгэж, зэсийн үнийг өсгөж болзошгүйг харуулж байна. Биржийн нөөцийн бууралт нь эрэлт нэмэгдэж эсвэл нийлүүлэлтийн тасалдалтай холбоотой байж болох бөгөөд энэ нь үнэ өсөхөд нөлөөлнө. Иймд зэсийн үнэд биржийн хувьцааны нөлөөлөл нь хувьцааны өөрчлөлтийн чиглэлээс хамаарч сөрөг болон эерэг аль аль нь байж болно.

**ДҮГНЭЛТ**

Энэхүү судалгааны ажил манай улсын экспортын голлох бүтээгдэхүүн болох зэсийн дэлхийн зах зээл дээрх үнэ, түүнд нөлөөлөгч гол хүчин зүйлүүд, тэдгээрийн хамаарал болон үнийн өөр өөр мөчлөгт үзүүлэх нөлөөллийг шинжлэхийг зорилгоо болгосон билээ. Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн талаарх судалгаа нь нэлээн өргөн хүрээнд хийгддэг бөгөөд аливаа түүхий эдийн үнэ болон түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тойрсон олон арван маргаан байдаг. Судалгааны ажлын эхний 2 бүлэгт манай улсын эдийн засгийн сайн сайхан байдалтай нягт холбоотой түүхий эд болох зэсийн үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар судлаачийн өнцгөөс таамаглал дэвшүүлж, энэхүү асуудлыг тойрсон судалгааны ажил болон суурь ойлголт, хамаарлын талаар мэдээлэл өгөхийг зорилгоо.

## ДААТГАЛЫН ХУРААМЖ ГЭЖ ЮУ ВЭ?



Даатгалын хураамж – даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөр.

Даатгалын хураамжийн хэмжээг тогтооход дараах зарчмыг баримтална:



даатгагч, даатгуулагч нарын эрх ашигт нийцсэн байх



тогтвортой байх



нөхөн төлбөр төлөхөд хүрэлцээтэй, үйл ажиллагааны зардлыг бүрэн нөхөхүйц байх



даатгалын бүтээгдэхүүний гэрээний нөхцөлтэй уялдсан байх



хураамжийг нэг удаа бүрэн төлөх, эсвэл даатгалын гэрээний хугацаанд үе шаттайгаар хэсэгчлэн төлөх



эрсдэлд өртөж болзошгүй объект, өртөх магадлал, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр ялгавартай тооцох

## ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?

**Даатгалын нөхөн төлбөр** – гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө.



**Жолоочийн даатгалын нөхөн төлбөр:** жолоочийн даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгалын гэрээний дагуу даатгагчаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгө.

Даатгалын гэрээгээр даатгалын нөхөн төлбөр олгох боломжгүй бол жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

### Даатгалын нөхөн төлбөрийг хэрхэн олгодог вэ?



Даатгалын компанитай утсаар болон цахимаар яаралтай холбогдож даатгалын тохиолдлыг баталгаажуулах



Холбогдох мэргэжлийн байгууллагад хандах. /Замын цагдаагийн газар, Цагдаагийн газар, Яаралтай түргэн тусламж, ОБЕГ, Гал унтраах анги гэх мэт/



Осол болсон орчин нөхцөлийг харуулан зураг авч баталгаажуулах

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



### ЯПОН УЛСЫН КОРПОРАЦЫН ИНФЛЯЦ 03 ДУГААР САРД 0.8 ХУВЬ БОЛЖ ӨССӨН НЬ ХҮЛЭЭЛТТЭЙ НИЙЦЖЭЭ.

Япон улсын корпорацийн үнийн индекс 2024 оны 3 дугаар сард Ройтерс агентлагийн шинжээчдийн таамаглаж байсан төсөөллийг ахиулан 0.8 хувиар өссөн нь 2 дугаар сард шинжээчдийн шинэчлэн таамагласан 0.7 хувийн өсөлтийг давуулсан үзүүлэлт юм.

Корпорацийн инфляцын түвшин гурван сар дараалан 0.2 хувийн өсөлтийг үзүүлсэн нь Ройтерс агентлагийн шинжээчдийн 0.3 хувийн өсөлтийн хүлээлтэд хүрээгүй буюу бага зэрэг доогуур байна.

Компорацийн барааны үнийн индекс (CGPI) нь корпорацийн секторт худалдаалагдаж буй барааны үнийн өөрчлөлтийг хэмждэг.

Эх сурвалж: [www.Cnbc.com](http://www.Cnbc.com)

### КАНАДЫН НЬОФАУНДЛЕНД, ЛАБРАДОР МУЖ WORLD ENERGY-ИЙН УСТӨРӨГЧИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШӨӨРӨВ.

Канадын Ньюфаундленд, Лабрадор (Newfoundland and Labrador) мужид 03 дугаар сар хүртэл нүүрстөрөгч багатай устөрөгч үйлдвэрлэх 80 гаруй төслийг зарласан бөгөөд үүний дараа 04 дүгээр сарын 9-ний өдөр сэргээгдэх эрчим хүчний World Energy компанийн устөрөгчийн үйлдвэрийг зөвшөөрөв.

Nujio'qonik нэртэй уг төсөл нь чулуужсан түлш ашигладаг уламжлалт аргуудаас ялгаатай нь цэвэр эрчим хүчний эх үүсвэрээр ногоон Hydrogen болон Ammonia үйлдвэрлэн арилжаалах хүчин чадалтай үйлдвэр юм.

Тус мужийн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Бернард Дэвис (Bernard Davis) хэлэхдээ "Уг төсөл нь байгаль орчны үнэлгээний актад тавигдах шаардлагыг хангасан байна." гэжээ.

Тус мужийн баруун эргийн салхины төслүүдээр дамжуулан гурван гигаваатт гаруй сэргээгдэх цахилгаан эрчим хүчний тусламжтайгаар энэ төсөл жилд 250,000 орчим тонн устөрөгч үйлдвэрлэх төлөвтэй байна.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)





## ДОЛЛАР ИЕНТЭЙ ХАРЬЦАХ ХАНШ 1990 ОНЫ ДУНД ҮЕЭС ХОЙШИХ ХАМГИЙН ӨНДӨР ТҮВШИНДЭЭ ХҮРЧЭЭ.

Гуравдугаар сард инфляц хүлээгдэж байснаас 04 дүгээр сарын 10-ны өдөр ам.долларын ханш огцом өсөж, 1990 оны дунд үеэс хойш Японы иентэй харьцах хамгийн дээд түвшиндээ хүрэв.

Голлох зургаан валюттай харьцах ам.долларын ханш 1.1 хувиар өсөж 105.22 болсон байна. Иений эсрэг ам.долларын ханш 0.7 хувиар өсөж 152.95-д хүрсэн нь 1990 оны дунд үеэс хойших хамгийн дээд цэг ажээ.

Эх сурвалж: [www.Cnbc.com](http://www.Cnbc.com)

## DEUTSCHE BANK-НЫ АШИГ 2024 ОНЫ ЭХНИЙ УЛИРЛЫН БАЙДЛААР 10 ХУВИАР ӨССӨН ГЭЖ МЭДЭЭЛЭВ.

Deutsche Bank энэ оны эхний улиралд 1.275 тэрбум евро (1.365 тэрбум ам.доллар)-ийн цэвэр ашиг олсон нь өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Лондонгийн хөрөнгийн бирж групп (LSEG)-ын өгөгдлийн дагуу шинжээчид энэ хугацаанд 1.23 тэрбум евро болно гэж таамаглаж байсан.

Орлого нь жилийн өмнөхөөс 1 хувиар өсч, 7.8 тэрбум евро болсныг шимтгэл, хураамжийн орлогын өсөлт, тогтмол орлого, валютын ханшийн өсөлттэй холбон тайлбарлав. LSEG-ийн мэдээлснээр орлого нь шинжээчдийн таамаглаж байсан 7.73 тэрбум еврог давсан үр дүнтэй байна.



Эх сурвалж: [www.Cnbc.com](http://www.Cnbc.com)

## АНУ-ЫН ДНБ-ИЙ ТАЙЛАН ЦАГААЧЛАЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ОНЦЛОН ХАРУУЛАВ.

Хувийн болон засгийн газрын хэрэглээ, барилгажилт эхний улирлын эдийн өсөлтийг дэмжсэн байх;

Өндөр хүүтэй үед бизнесийн хөрөнгө оруулалт зогссон байх магадлалтай.


АНУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 2024 оны эхний улирлын тоон мэдээлэл нь цагаачлалын өсөлтөөс

үүдсэн эдийн засгийн өсөлтийг харуулж байна.

Эдийн засгийн шинжилгээний товчоо (Bureau of Economic Analysis)-ны зурган баримтад ДНБ оны эхний гурван сард 2.5 хувиар өссөнийг харуулж байна. Хэрэглээний зардал 3.0 хувиар өссөн байна.

Эх сурвалж: [Bloomberg.com](http://Bloomberg.com)

Зураг. АНУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүн: улирлын өөрчлөлт



Эх сурвалж: [US Bureau of Economic Analysis, Bloomberg](http://US Bureau of Economic Analysis, Bloomberg)

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр

S&P 500 (^GSPC)

**5,071.63** +1.08 (+0.02%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

Nikkei 225 (^N225)

**37,818.11** -641.97 (-1.67%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

FTSE 100 (^FTSE)

**8,040.38** -4.43 (-0.06%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

NASDAQ Composite (^IXIC)

**15,712.75** -16.11 (+0.10%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia